Хөшөөтийн голын хөндийд өрөмдсөн цооног болон булгийн усны химийн шинжилгээг 2012 оноос хойш тасралтгүй буюу сард 1 удаа Шинжлэх ухааны академи, Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн усны лабораторид шинжилгээ хийлгэж ирсэн ба бүх үзүүлэлт нь ундны усны стандарт

хангаж, хүний унданд хэрэглэхэд тохиромжтой гэж тогтоосон байдаг. Өөрөөр хэлбэл, Химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонат ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэг, зөөлөвтөр ус байна.

Шинжилсэн бүх үзүүлэлтүүд нь “Ундны усны стандарт /MNS900:2005/-ын шаардлага хангаж байгаа учир хүний унданд хэрэглэхэд тохиромжтой” гэсэн дүгнэлтийг гаргасан байна. 2023 онд Бактерологи, ерөнхий хими, Хүнд метал зэрэг шинжилгээг ХАБҮЛ лаборатори, МУЗГХАгентлаг Усны газрын лабораторид өгсөн ба шинжилгээний үр дүнг хавсаргав.

Мөн ус ашиглалтыг зориулалтаар нь хянах зорилгоор Well-2 дугаартай худагт STD-815 АНД маркын гадна камер болон STD-791 АНД маркын дотор камерыг суурилуулсан. Худагт камер суурилуулснаар үйлдвэрлэлийн болон унд-ахуйн усны хэрэглээг зориулалтын машинд ачиж байгаа эсэхийг хянаж, ус ашиглалтын журналтай тулгаж баталгаажуулж байгаа болно. Мөн Хүйсийн Говь-Цэцэг нуурын сав газрын захиргаатай байгуулсан ус ашиглалтын гэрээнд тусгасны дагуу ус ашиглалтын хяналтын камерыг суурилуулсан болно.



Зураг 6. Худагт суурилуулсан ус ашиглалтын хяналтын камер

Хяналтын камер суурилуулахаас гадна цэвэр ус зөөвөрлөж буй машиныг тэмдэгжүүлж зориулалтаар нь ялгасан.



Зураг 7. Ус зөөвөрлөх машиныг зориулалтаар нь ялгасан байдал

1.10 Ашигласан усны хэмжээ

Хөшөөтийн уурхайн үйл ажиллагаа 2023 онд хөрс хуулалт хийх гэрээт компани болох Моннис ХХК, “Алтайн зам” ХК-иуд, нүүрс олборлолтын гэрээт компани болох Алтайн зам ХК, мөн Мезом ХХК, бусад гэрээт компаниудтай хамтран ажиллаж байна. Хөшөөтийн уурхайн унд-ахуйн ус, үйлдвэрлэлийн усны хэрэглээг нэг эх үүсвэрээс 2 тоолуураар авч ашиглаж байна.

Хөшөөтийн уурхайд 2023 оны 9-р сарын эцсийн байдлаар тухайн жилийн ажиллах хүчний ашигласан унд-ахуйн усны хэмжээтэй харьцуулж 1 хүн дунджаар 110 литр усыг хоногт хэрэглэсэн тооцоо доорх хүснэгтээс харна уу.

Хүснэгт 5. Унд-ахуйн ус ашиглалт (Нэг хүний хоногийн хэрэглээг тооцсон байдал)

Month/Date - Огноо	2023 он											
	Dec	Jan	Feb	Mar	Apr	May	Jun	Jul	Aug	Sep	Oct	Nov
Нийт хүний тоо	459	449	447	435	434	453	439	443	470	541		
Сарын хэрэглээ, м3/сар	1,540	1,647.00	1308	1450	1585	1587	1595	1621	1640	1479	-	-
Хоногийн хэрэглээ, м3/хоног	50	53	45	47	53	51	53	52	53	49	-	-
Нэг хүний хэрэглээ, л/хоног*хүн	108	118	101	108	122	113	121	118	113	91		

График 1. Хөшөөтийн уурхайн 2023 онд ашигласан гүний усны хэмжээ





График 2. Хөшөөтийн уурхайн 2023 онд шүүрлийн усыг шавхан зайлуулсан хэмжээ



Хүснэгт 6. Хөшөөтийн уурхайн 2023 оны жилийн ашигласан усны хэмжээ, 09 дугаар сарын 30 -ны байдлаар

№	Огноо	Унд, ахуйн ус	МоЭнКо ХХК-ийн Үйлдвэрлэлийн ус					Алтайн зам компанийн үйлдвэрлэлийн ус	Мезом компанийн үйлдвэрлэлийн ус	Моннис компанийн үйлдвэрлэлийн ус	Унд, ахуйн усны хоногийн дундаж хэрэглээ, м3	Үйлдвэрлэлийн усны хоногийн дундаж хэрэглээ, м3	Сарын ундны усны нийт хэрэглээ, м3	Сарын үйлдвэрлэлийн усны нийт хэрэглээ, м3	Сарын нийт хэрэглээ, м3
			Нийт	Зам талбайн тоосжилт, бусад	Онцгой байдал, гал	Ногоон байгууламж	Эрэл хайгуул өрөмдлөг								
1	2023.1.31	1,647	264	263	1			118			53	12	1,647	382	2,293
2	2023.2.28	1,308	298	292	6			1,928			45	72	1,308	2,226	3,832
3	2023.3.31	1,450	1,623	1,618	5			6,766	578		47	289	1,450	8,967	12,040
4	2023.4.30	1,585	1,796	1,762	34			8,328	1,910		53	388	1,585	12,034	15,415
5	2023.5.31	1,587	2,075	1,848	55		172	8,317	1,539		51	385	1,587	11,931	15,593
6	2023.6.30	1,595	4,998	4,831	31		136	11,018	1,506		53	565	1,595	17,522	24,115
7	2023.7.31	1,621	4,096	3,865	26	52	153	11,481	1,988		52	567	1,621	17,565	23,282
8	2023.8.31	1,640	4,463	4,323	60	15	65	9,565	2,777	2,999	53	542	1,640	16,805	22,908
9	2023.9.30	1,479	3,805	3,592	12	37	164	10,133	1,262	2,468	49	490	1,479	15,200	20,484
10	2023.10.31	1,729	3,737	3,609	31	-	97	10,145	2,470	3,623	56	527	1,729	16,352	21,818
11	2023.11.30	2,224	523	516	7			1,656	325	577	74	81	2,224	2,504	5,251
12	2023.12.31		-								-	-	-	-	-
	Нийт хэрэглээ	17,865	27,678	26,519	268	104	787	79,455	14,355	9,667	49	327	17,865	121,488	167,031

Хүснэгт 7. Хөшөөтийн уурхайн 2023 оны жилийн ашигласан шүүрлийн усны хэмжээ, 09 дүгээр сарын 30-ны байдлаар

2023 оны Хөшөөтийн уурхайн Шүүрлийн усны хэрэглээ											
№		МоЭнКо ХХК- ийн шүүрлийн усны хэрэглээ	Мезом компанийн шүүрлийн усны хэрэглээ	Алтайн зам компанийн шүүрлийн усны хэрэглээ	Моннис компани йн шүүрлийн усны хэрэглээ	Сарын нийт хэрэглээ, м3	МоЭнКо ХХК-ийн шүүрлийн усны хоногийн дундаж хэрэглээ, м3/хоног	Мезом компанийн шүүрлийн усны хоногийн дундаж хэрэглээ, м3/хоног	Алтайн зам компанийн шүүрлийн усны хоногийн дундаж хэрэглээ, м3/хоног	Моннис компанийн шүүрлийн усны хоногийн дундаж хэрэглээ, м3/хоног	Ус авч буй PIT
1	2023.1.31					-	-	-	-	-	PIT-1, RL2007
2	2023.2.28					-	-	-	-	-	PIT-1, RL2007
3	2023.3.31					-	-	-	-	-	PIT-1, RL2007
4	2023.4.30					-	-	-	-	-	PIT-1, RL2007
5	2023.5.31	50	199	394		643	1.67	6.63	13.13	-	PIT-1, RL2007
6	2023.6.30	354	4,729.00	6,225.00		11,308.00	11.8	157.63	207.5	-	PIT-1, RL2007
7	2023.7.31	12	4,260.00	1,922.00		6,194.00	0.4	142	64.07	-	PIT-1, RL2007
8	2023.8.31	68	2,695.00	2,750.00	11	5,524.00	2.19	86.94	88.71	0.35	PIT-1, RL2007
9	2023.9.30		3,699.00	1,036.00		4,735.00	-	123.3	34.53	-	PIT-1, RL2007
10	2023.10.31					-	-	-	-	-	PIT-1, RL2007
11	2023.11.30					-	-	-	-	-	PIT-1, RL2007
12	2023.12.31					-	-	-	-	-	PIT-1, RL2007
	Нийт хэрэглээ	484.00	15,582.00	12,327.00	11.00	28,404.00					

Хөшөөтийн уурхайн ус ашиглалтын төлбөрийг ус ашиглах гэрээний дагуу Худгийн тоолуурын заалт болон шүүрлийн ус ашигласан бүртгэлийг үндэслэн сард нэг удаа Ховд аймгийн төрийн сангийн дансанд төлж байгаа болно. Үүнд гэрээт компаниудын ус ашигласны төлбөр орно.

2023 оны 09 сарын эцсийн байдлаар унд ахуй болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны хэмжээг доорх байдлаар харуулав.

Үүнд:

- Унд ахуй – 17,865 шоо метр ус
- Зам талбайн тоосжилт – 129996 шоо метр ус /1 шоо метр ус 188,16 төгрөг/
- Мод, ногоон байгууламжийн усалгаа – 104 шоо метр ус /1 шоо метр ус 141,12 төгрөг/
- Болзошгүй галын аюулын сургалтад ашиглаж буй хэрэглээ – 268 шоо метр
- Өрөмдлөгийн ажил –787 шоо метр ус /1 шоо метр ус 799,68 төгрөг/
- Ус шавхан зайлуулалт буюу шүүрэл – 38880 шоо метр ус /1 шоо метр ус 635,04 төгрөг/

2023 онд МоЭнКо ХХК Хөшөөтийн уурхайн ус ашигласны төлбөрт нийт 41,686,518.72 төгрөгийг Ховд аймгийн төрийн санд төлсөн байна.

Үенч дахь гаалийн хяналтын талбай нь 2023 оны эхний улиралд ажиллагаатай байсан ба энэ хугацаанд нийт ашигласан усны хэмжээг доорх байдлаар харуулж байна.

Хүснэгт 8. Усны зарцуулалт

№	Огноо	Унд, ахуйн ус	МоЭнКо ХХК-ийн үйлдвэрлэлийн усны хэрэглээ		
			Ногоон байгууламж	Зам талбайн тоосжилт, бусад	Сарын нийт хэрэглээ, м3
1	2023.1.31	1,647		263	2,293
2	2023.2.28	1,308		292	3,832
3	2023.3.31	1,450		1,618	12,040
4	2023.4.30	1,585		1,762	15,415
5	2023.5.31	1,587		1,848	15,593
6	2023.6.30	1,595		4,831	24,115
7	2023.7.31	1,621	52	3,865	23,282
8	2023.8.31	1,640	15	4,323	22,908
9	2023.9.30	1,479	37	3,592	20,484
10	2023.10.31	1,729	-	3,609	21,818
11	2023.11.30	2,224		516	5,251
12	2023.12.31				-
	Нийт хэрэглээ	17,865	104	26,519	167,031

Үенчийн гаалийн талбайд ашигласан усны нийт төлбөр 166,008.57 төгрөгийг Ховд аймгийн төрийн санд төлсөн байна.

1.11 Ажиллах хүчний тухай мэдээлэл

Хөшөөтийн уурхайн хүрээнд 2023 оны 10 дугаар сарын 10-ны байдлаар нийтдээ 2563 ажиллагсад байгаа бөгөөд дараах компанийн ажилтнууд ажиллаж байна. Үүнд:

Хүснэгт 9. Ажиллах хүчний мэдээлэл

Хөшөөт төсөл ажиллах хүчний мэдээлэл-2023.10.10		
№	Байгууллагын нэр	Ажилтнуудын тоо
1	МоЭнКо ХХК Хөшөөтийн уурхай	541
2	МоЭнКо ХХК УБ оффис	
3	Эм И Си Транс	47
МоЭнКо ХХК-ийн туслан гүйцэтгэгч байгууллагууд		
1	Бумбат зүрх ХХК	51
2	Номадс ХХК	78
3	Эммед Партнер ХХК	7
4	Алтайн Зам ХК	615
5	Мезом ХХК	196
6	Моннис ХХК	218
7	Нүүрс тээвэр 25 компани	810
Төслийн нийт ажиллах хүч		2563

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	Экспортын нүүрс тээвэрлэлтийн зам дагуу нүүрс тээврийн машинаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор тээврийн машины чиргүүлийг бүтээлэгтэй байхад хяналт тавих.	Нүүрс тээврийн 311км зам дагуу	Гэрээгээр нүүрс тээвэр хийж буй тээврийн компаниудын зардлаас	Тогтмол	Нүүрс ачилтын талбайгаас экспортын нүүрс ачсан шалаанз машин нүүрс пүүлэх хэсгээр дамжиж хучлагын талбайд зогсон чиргүүлээ зориулалтын хучлагаар хучуулж гаалийн байцаагчийн лац тавиулсны дараа экспортын тээвэрлэлтэд гарч байна. Чиргүүлийн хучлагын бүрэн бүтэн байдлыг тогтмол хянаж урагдсан, шаардлага хангахгүй хучлагыг солиулах арга хэмжээ авч, хяналт тавьж байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 2.1 дүгээр бүлгээс харна уу.	MNS 4585 :2016 Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага
2	Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр	Уурхайн технологийн замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор зам усалгаа хийх.	Төслийн зам талбай	0	Тогтмол	Олборлолтын талбайн замын хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөнийг зохицуулах, хурдны хязгаарыг баримтжуулахад дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Уурхайн талбай доторх замуудад хурдны хязгаарын 5, 10, 30 км/ц тэмдгүүдийг байрлуулсан. Уурхайн технологийн зам усалгааг туслан гүйцэтгэгч гэрээт компаниудын нийт 6 усны машинаар дулааны улиралд өдөр бүр тогтмол хийж байна. 2023 оны 09 дүгээр сарын 30 өдрийн байдлаар 129996 шоо метр ус зарцуулсан байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 2.2 дүгээр бүлгээс харна уу.	Байгаль хамгаалах тухай хууль Агаарын тухай хууль, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга
3		Замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор замын засвар, арчилгааг тогтмол хийх.	Төслийн зам талбай	Үйл ажиллагааны зардлаас	Тогтмол	Уурхайн гадна талбайн замуудад хурдны хязгаарыг тэмдгүүдийг шаардлагатай газруудад байрлуулсан. Нүүрс тээврийн машинуудын хурд, байршлыг хянах зорилгоор GPS суурилуулж тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөнийг хянадаг. Мөн АНУ-д үйлдвэрлэсэн Bushnell IUW38006 маркийн хурд хэмжигч багаж ашиглан хурд хэтрүүлсэн жолооч оператор нарт зөрчил бичиж, арга хэмжээ авч ажиллаж байна. Хөшөөтийн уурхайгаас Ярантын боомт хүртэлх нүүрс	

						<p>тээврийн 311 км хатуу хучилттай замын засвар, арчилгааны ажлыг Алтайн зам ХК гэрээгээр хийж гүйцэтгэсэн: Үүнд</p> <ul style="list-style-type: none"> • 27878 м2 эвдэрсэн хучилтыг 5 см зузаантай асфалтбетоноор зассан, • 3500 м2 цементбетон зам барих, 45000 метр урт гагнаас хийх. • 5000м2 уулын шуудууг цемент бетон зуурмагаар засах , • 50 ширхэг замын тэмдэг 200 ширхэг дохионы шонг шинээр суурилуулах 8560 м3 зогсоол барих ажлыг хийж гүйцэтгэсэн. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 2.3 дүгээр бүлгээс харна уу. 	
4		<p>Техник хэрэгслүүдийн эвдрэл гэмтлийг хянаж, техникийн хэвийн ажлын горимыг ханган ажиллах, тээврийн хэрэгслийн яндангаас ялгарах хорт утааг үйлдвэрлэгчээс гаргасан хэм хэмжээнд байлгах, үзлэг оношилгоонд хамруулах.</p>	<p>Төслийн талбайд ашиглагдаж байгаа хөнгөн тэрэгнүүд</p>	0	Тогтмол	<p>Хөшөөтийн уурхай дээр ажиллаж байгаа техник хэрэгслүүдийн эвдрэл гэмтлийг мэргэжлийн засвар үйлчилгээний баг бүрэлдэхүүн тогтмол хянаж, шаардлагатай засвар үйлчилгээг хийж ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Өдөр бүрийн ажил эхлэхийн өмнөх техникийн тойрох үзлэг • Улиралд нэг удаагийн үзлэг • Авто тээврийн улсын үзлэг <p>Тээврийн хэрэгслийн яндангаас ялгарах хаягдал утаан дахь агаар бохирдуулах бодисыг хэмжиж, үнэлгээ, дүгнэлт өгөх хяналт, хэмжилийн ажлын хүрээнд МоЭнКо ХХК-ийн 52 авто тээврийн хэрэгслийг авто тээврийн хяналтын улсын үзлэг оношилгоонд оруулсан. Тус техникүүд нь тээврийн хэрэгсэлийн хорт утааны хэмжээ стандарт нийцэж хэвийн гарсан. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 2.4 дүгээр бүлгээс харна уу.</p>	

5		Уурхайн шүүрлийн усыг шинжилгээнд өгч тоосжилт бууруулах зорилгоор технологийн зам усалгаанд ашиглах. (улиралд нэг удаа шинжилгээнд хамруулах)	Төслийн зам талбай	0	Тогтмол	2023 онд бактериологи, ерөнхий хими, хүнд метал зэрэг шинжилгээг ХАБҮЛ-ийн лаборатори, МУЗГХАгентлаг Усны газрын лабораторид өгсөн ба шинжилгээний үр дүнг хавсаргав. 2023 оны 9 сарын 30-ны өдрийн байдлаар Ус шавхан зайлуулалт буюу шүүрэл – 38880 шоо метр ус шавхан ашигласан байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 2.5 дугаар бүлгээс харна уу.	Усны тухай хууль
6	Гадаргын болон газрын доорхи усны нөөц	Хөшөөт гол, Түвшин буйр, Тахилтын булгийн эх ба уст цэгүүдийг цэвэрлэх арга хэмжээ зохион байгуулах.	Төслийн талбай орчмын уст цэгүүд	Үйл ажиллагааны зардлаас	Сар бүр	Уурхай орчмын уст цэгүүд болох Хөшөөтийн гол, Түвшин буйрын рашаан, Тахилтын булгийн ойр орчмын хог хаягдлын цэвэрлэгээг сар бүр тогтмол хийж байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 2.6 дугаар бүлгээс харна уу.	Усны тухай хууль
7		Хүйсийн говь, Цэцэг нуурын сав газрын захиргаатай ус ашиглах гэрээ байгуулж, ус ашигласны төлбөр төлөх	Усан хангамжийн эх үүсвэр, шүүрлийн ус	Гэрээнд заасны дагуу төлбөр төлөгдөнө	Гэрээнд заасан хугацаа бүрт	МУ-ын Усны тухай хуулийн дагуу Монгол улсын ЗГ-ийн хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2023.08.09 өдрийн 01-926 тоот Ус ашиглах дүгнэлт, Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргааны 2023.08.10 өдрийн А/09 тоот Ус ашиглах зөвшөөрөл, Хүйсийн Говь-Цэцэг нуурын сав газрын захиргаа болон МоЭнКо ХХК-ийн хооронд байгуулсан 2023.08.12 өдрийн №02/2023 тоот Ус ашиглах гэрээ, Ховд аймгийн БОАЖГазрын 2020.07.08 өдрийн 2020/01 дугаар Ус ашиглах эрхийн бичиг (2023.09.26-г хүртэл 1 жилээр сунгалт хийгдсэн) зэрэг баримт бичгийг дээрх хуулийн хүрээнд бүрдүүлж ажиллаж байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 1.10 дугаар бүлгээс харна уу.	Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс, ус ашиглах эрхийн бичгийн загварыг шинэчлэн батлах тухай (БОАЖС-ын 2018 оны 10 сарын 02-ны өдрийн А/376 дугаар тушаал)
8	Усны чанар алдагдах	Ундны усны эх үүсвэр бохирдохоос сэргийлэх, усыг тогтмол шинжлэх, гүний хоолойн бохирдол үүсэх асуудлыг хянах.	Уурхайн ашиглалтын худаг, Үенч ГХТ худаг	Зардлын утга ОХШХ-т орсон	Улирал тутам	Хөшөөтийн уурхайн ундны усан хангамжийг Хөшөөт голын хөндийд байрлах Well-2 худгаас хангадаг. Ундны усны дээжийг улиралд 1 удаа ХАБҮЛ лаборатори, МУЗГХАгентлаг Усны газрын лабораторид бактериологи, ерөнхий хими, хүнд металлын шинжилгээнд хамруулж байна.	Усны тухай хууль, MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага

9		Аливаа газар хөндөх үйл ажиллагааны өмнө шимт хөрс болон шимэрхэг хөрсний гүнийг талбай тус бүрд тогтоож, тогтоосон хэмжээнд хуулж, хадгалах. (шинээр хөрс хуулах бүрт)	Шимт хөрсний овоолго	Үйл ажиллагааны зардлаас	Тогтмол	2023 онд уурхайн ашиглалт, отвалын үйл ажиллагааны зориулалттай 48 га талбайн шимт хөрс хуулж нийт 52,660.1 м3 буюу 63,198.16 тонн хөрсийг шинээр хуулж хадгалсан. Нийт 109,309.3 м3 буюу 131,171.2 тонн шимт хөрсийг MNS 5916:2008 стандартын дагуу хадгалж байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 2.9 дугаар бүлгээс харна уу.	Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5859:2008 “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ” Байгаль орчны аудитын үл нийцэл
10	Хөрсөн бүрхэвч	Түлш шатах, тослох материалаар хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх, асгаралт үүссэн талбайг цэвэрлэх, хөрсийг саармагжуулах	Төслийн талбай	Үйл ажиллагааны зардлаас	Тогтмол	Асгаралтаас хамгаалах иж бүрдлийг шаардлагатай газруудад байрлуулан асгаралт үүссэн тохиолдолд ашиглаж байна. Мөн хөрсний бохирдолыг саармагжуулах, цэвэршүүлэх зорилгоор “Ашигтай бичил биетний био бэлдмэл EM-1” ашиглаж байна. Дээрх бодисыг засварын газар, түлш түгээх цэг, генераторуудын орчимд ашигладаг. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 2.8 дугаар бүлгээс харна уу.	
11		Ашигласан тос, тосолгооны материал хадгалах талбай байгуулах, таних тэмдэг самбар байрлуулах.	Засварын газруудад	Үйл ажиллагааны зардлаас	Нэг удаа	Ашигласан тос, тосолгооны материал хадгалах талбайн ажил нь манай компанийн засварын газар шинэ суурьшлын талбайд нүүж очиж байгаатай холбоотой шинээр тус талбайг бэлдэж байна. Үүнд шатах тослох материал түр хадгалах, ангилан ялгах талбайн ажил хийгдээд хадгалалт болон ангилан ялгах ажлуудыг шат дараатай хэрэгжүүлэн ажилласан. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 2.7 дугаар бүлгээс харна уу.	
12	Амьтны аймаг	Цаг хүндэрсэн үед уурхайн нөлөөллийн бүс дэх зэрлэг ан амьтанд биотехникийн арга хэмжээг авах	Сутай хайрхан УСТГ нутаг	12,550,000	Тогтмол	Тус ажлын хүрээнд Үенч, Дарви, Цэцэг сумдын нутаг дэвсгэрт хамаарах улсын болон орон нутгийн ТХГ нутагт 350 пресс өвс, 3 тонн хужир тавьж өгч биотехникийн арга хэмжээ авч ажилласан. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 2.10 дүгээр бүлгээс харна уу.	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Амьтны тухай хууль
13	Дуу чимээ, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нөлөөгөөр байршиж буй	Дуу чимээний хэмжилтийг тогтоосон цэгүүдэд хийж мэдээлэлд дүгнэлт хийх.	Уурхайн хэмжилтийн 10 цэгт	Үйл ажиллагааны зардлаас	Тогтмол	Дуу шуугианы түвшнийг уурхай орчмын 10 цэгт Digital Environment Multimeter EM5 багажаар 14 хоногт 1 удаагийн давтамжтай хийж мэдээг бүртгэж байна. Монгол Улсын дуу чимээний стандарт (MNS4585:2016) болон ДЭМБ-ын заавар дахь хүлцэх хэм хэмжээнээс даваагүй	

	нутгаасаа үргэх, дайжих					хэвийн байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 2.10 дүгээр бүлгээс харна уу.	
14	Хуурай баяжуулах үйлдвэр болон гаалийн хяналтын ачиж буулгах талбайд тоосжилт бий болох	Хуурай баяжуулах үйлдвэрийн тэжээлийн талбай, Гаалийн хяналтын талбайн ачиж буулгах үйл ажиллагаанаас үүсэх нүүрсний нарийн ширхэгт тоосонцрын дэгдэлтийг бууруулах зорилгоор мананжуулагч машинаар усалгаа хийх	Хуурай баяжуулах үйлдвэрийн тэжээлийн талбай, Нүүрс ачиж, буулгах талбай	Үйл ажиллагааны зардлаас	Тогтмол	Хуурай баяжуулах үйлдвэр, гаалийн хяналтын талбайн ачилтын талбайгаас үүсэх тоосны хэмжээг бууруулах сөрөг нөлөөллийг багасгах үүднээс 4 мананжуулагч машинаар мананжуулах усалгаа хийж байна. Мананжуулагч машин нь агаарт дэгдэх тоос руу усыг мананцар болгон өндөр даралтаар цацсанаар барьцалдуулан газарт буулгадаг ач холбогдолтой. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 2.11 дүгээр бүлгээс харна уу.	MNS 4585 :2016 Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага Байгаль хамгаалах тухай хууль Агаарын тухай хууль
Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал, мян.төг				12,550,000			

НҮҮРС ХУУРАЙ АРГААР БАЯЖУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Одоогоор нөхөн сэргээлт хийх талбай байхгүй.	Хуурай баяжуулах үйлдвэрийн тэжээлийн талбай	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүр	Одоогоор нөхөн сэргээлт хийх талбай байхгүй байна.	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт стандарт MNS_5914_2008
2	Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсний шинэ овоолгийн үржил шимийг алдагдуулахгүй хадгалалтыг уртасгахын тулд ургамалжуулах ажлыг үргэлжлүүлэх, олон наст ургамлын тариалалт хийх	Нүүрс ачиж, буулгах талбай	Үйл ажиллагааны зардлаас	Жил бүр	Уурхайн ашиглалт, отвалын үйл ажиллагааны зориулалттай 48 га талбайн шимт хөрс хуулж нийт 52,660.1 м3 буюу 63,198.16 тонн хөрсийг шинээр хуулж хадгалсан. Нийт 109,309.3м3 буюу 131,171.2 тонн шимт хөрсийг MNS 5916:2008 стандартын дагуу хадгалж байна.	Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008
3		Уурхайн орчмын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх мод тарих		Үйл ажиллагааны зардлаас	Жил бүр	Тус онд ажилчдын амрах байр, кемп орчмын ногоон байгууламжийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Засварын газар нүүлгэн шилжүүлсэнтэй холбоотой хуучин засварын газрын ургаж байсан	MNS 6774:2019 Том мод, суулгацыг шилжүүлэн

						мод, суулгацыг шилжүүлэн суулгаж арчилж ургуулах ажил хийгдсэн.	суулгах, арчлах. Техникийн шаардлага
4	Татан буулгах, хаалтад бэлтгэх	Одоогоор татан буулгах, хаалтад бэлтгэх талбай байхгүй.		Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүр	Одоогоор татан буулгах хаалтад бэлтгэх талбай байхгүй.	Байгаль орчны аудитын үл нийцлийг арилгах төлөвлөгөө
Сөрөг нөлөөллийг бууруулах нийт зардал, мян.төг				Үйл ажиллагааны зардлаас			

2. Агаарын орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

2.1 Экспортын нүүрс тээвэрлэлтийн зам дагуу үүсэх тоосжилт, агаарын бохирдлоос урьдчилан сэргийлж нүүрс тээврийн машины чиргүүлийг бүтээлэгтэй байхад хяналт тавих

Нүүрс ачилтын талбайгаас экспортын нүүрс ачсан шалаанз машин нүүрс пүүлэх хэсгээр дамжиж, хучлагын талбайд зогсон чиргүүлээ зориулалтын хучлагаар хучуулж, гаалийн хяналтын улсын байцаагчийн лац тавьсны дараа экспортын тээвэрлэлтэд гарч байна. Чиргүүлийн хучлагын бүрэн бүтэн байдлыг тогтмол хянаж урагдсан, шаардлага хангахгүй хучлагыг солиулж, хяналт тавин ажиллаж байна.



Зураг 8. Нүүрс тээврийн машины хучлагын хэсгийн ажиллагаа

2.2 Уурхайн технологийн замаас үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор технологийн замын усалгаа

Олборлолтын талбайн замын хөдөлгөөнөөс үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөнийг зохицуулах, хурдны хязгаарыг баримтжуулахад дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Уурхайн талбай доторх замуудад хурдны хязгаарын 5, 10, 30 км/ц тэмдгүүдийг байрлуулсан. Уурхайн технологийн зам усалгааг туслан гүйцэтгэгч гэрээт компаниудын нийт 6 усны машинаар дулааны улиралд өдөр бүр тогтмол хийж байна. 2023 оны 09 дүгээр сарын 30 өдрийн байдлаар 129996 шоо метр ус зарцуулсан байна.



Зураг 9. Уурхайн технологийн зам усалгаа

2.3 Уурхайн замаас үүсэх тоосжилтыг бууруулах хурдны хязгаарыг дагаж мөрдүүлэхэд хяналт тавьж, үүсэх тоосыг бага байлгах (хурдны хязгаарын тэмдэг тэмдэглэгээ)

Нүүрс тээврийн зам дагуу шаардлагатай газруудад хурдны хязгаарыг мөрдүүлэх үүднээс 20, 30, 40, 60 км/ц тэмдгүүд, хурд сааруулагч байрлуулсан. Нүүрс тээврийн машинуудын хурдыг хянах үүднээс АНУ-д үйлдвэрлэсэн Bushnell IUW38006 маркийн хурд хэмжигч багаж ашиглан хурд хэтрүүлсэн жолооч оператор нарт зөрчил арилгах арга хэмжээ авч ажиллаж байна. Мөн Хөшөөтийн уурхайгаас Ярантын боомт хүртэлх нүүрс тээврийн 311 км хатуу хучилттай замын засвар, арчилгааны ажлыг Алтайн зам ХК гэрээгээр дараах ажлуудын хийж гүйцэтгэсэн: Үүнд

- 27878 м² эвдэрсэн хучилтыг 5 см зузаантай асфалтбетоноор зассан,
- 3500 м² цементбетон зам барих, 45000 метр урт гагнаас хийх.
- 5000м² уулын шуудууг цемент бетон зуурмагаар засах, 50 ширхэг замын тэмдэг 200 ширхэг дохионы шонг шинээр суурилуулах 8560 м³ зогсоол барих ажлуудыг хийж гүйцэтгэсэн.



Зураг 10. АНУ-д үйлдвэрлэсэн Bushnell IUW38006 бхурд хэмжигч багаж,
нүүрс тээврийн 311км зам дагуух зам засварын ажил

2.4 Техник хэрэгслүүдийн эвдрэл гэмтлийг хянаж, техникийн хэвийн ажлын горимыг ханган тээврийн хэрэгслийн яндангаас ялгарах хийг үйлдвэрлэгчээс гаргасан хэм хэмжээнд байлгах Хөшөөтийн уурхай дээр ажиллаж байгаа техник хэрэгслүүдийн эвдрэл гэмтлийг мэргэжлийн засвар үйлчилгээний баг бүрэлдэхүүн тогтмол хянаж, шаардлагатай засвар үйлчилгээг хийж ажиллаж байна. Үүнд:

- Өдөр бүрийн ажил эхлэхийн өмнөх техникийн тойрох үзлэг
- Улиралд нэг удаагийн үзлэг
- Авто тээврийн улсын үзлэг

2023 оны авто тээврийн хэрэгслийн хяналтын улсын үзлэг оношилгоонд МоЭнКо ХХК-ийн 52 авто тээврийн хэрэгсэл үзлэгт оруулж тэнцсэн.



Зураг 11. Техникийн үзлэг оношилгоо, засвар үйлчилгээ

2.5 Гадаргын ба газрын доорхи усны нөөц

Уурхайн 1-р амнаас шүүрэх шүүрлийн усыг шинжилгээнд өгч, уг усыг технологийн хэрэгцээнд ашиглах

Уурхайн шүүрлийн усны дээжийг улиралд 1 удаа ХАБҮЛ лаборатори, МУЗГХАгентлаг Усны газрын лабораторид ерөнхий хими, хүнд металлын шинжилгээнд хамруулж технологийн зам усалгаанд ашиглаж байна. 2023 оны 09 дүгээр сарын 30-ний өдрийн байдлаар Ус шавхан зайлуулалт буюу шүүрэл - 33.026 шоо метр ус шавхан ашигласан байна.



Зураг 12. Шүүрлийн усны дээж авалт

2.6 Түвшин буйр, Тахилтын булгийн эх ба уст цэгүүдийг цэвэрлэх арга хэмжээ зохион байгуулах

Уурхай орчмын уст цэгүүд болох Хөшөөтийн гол, Түвшин буйрын рашаан, Тахилтын булаг ойр орчмын хог хаягдлын цэвэрлэгээг сар бүр тогтмол хийж байна. 2023 оны 5-10 сарын байдлаар уурхай орчмын уст цэгүүдийн цэвэрлэгээг нийт 6 удаа зохион байгуулсан байна. Дээрх уст цэгүүдийн эх орчимд хог хаягдал дулааны улиралд аялал жуулчлал, нутгийн айл өрхүүдийн зуслан, намаржааны нүүдэл суудалтай холбоотойгоор үүсч хуримтлагддаг.



Зураг 13. Уст цэгүүд орчмын хог хаягдлын цэвэрлэгээ

2.7 Хөрсөн бүрхэвч газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөөний биелэлт

Засварын цехүүдэд аюултай хог хаягдлын түр хадгалах цэг байгуулах:

Засвар үйлчилгээнээс гарсан хаягдал тос маслоны түр хадгалах 20 тонн багтаамжтай 2 ширхэг ёмкостыг тусгайлан засаж цементэлсэн талбайд байрлуулсан. Манай компанийн засварын газар шинэ суурьшлын бүсэд нүүж байршиж байгаатай холбоотой ашигласан тос, тосолгооны материал, аккумулятор, тос маслоны шүүр, агаар шүүгч зэрэг хог хаягдлыг түр хадгалах, ангилан ялгах талбайн ажлууд шат дараатай хийгдэж байна.



Зураг 14. Хаягдал тос масло, тос масолын сав түр хадгалах цэг

2.8 Түлш шатах, тослох материалаар хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх, асгаралт үүссэн талбайг цэвэрлэх, хөрсийг саармагжуулах

Асгаралтаас хамгаалах иж бүрдлийг шаардлагатай газруудад байрлуулан асгаралт үүссэн тохиолдолд ашиглаж байна. Мөн хөрсний бохирдлыг саармагжуулах, цэвэршүүлэх зорилгоор “Ашигтай бичил биетний био бэлдмэл EM-1” ашиглаж байна. Дээрх бодисыг засварын газар, түлш түгээх цэг, генераторуудын орчимд ашигладаг. Түлш шатах, тослох материалаар хөрс бохирдуулахаас урьдчилан сэргийлж, машин техникүүдийн бүрэн бүтэн байдлыг хангуулах, засвар үйлчилгээг зориулалтын засварын газар хийлгэх, тос масло солиход хэрэглэх иж бүрдлийг тогтмол ашиглуулах, гэрээт компанийн болон өөрийн компанийн засварын газар түүний гадна талбайд тос, тослох материалаар бохирдсон хөрсөнд хяналт тавьж түүнийг цэвэрлэх хөрсийг саармагжуулах ажлыг тогтмол хийж гүйцэтгэдэг.



Зураг 15. Асгаралтаас хамгаалах иж бүрдэл, ашигатай бичил биетний биобэлдмэл EM-1

2.9 Үржил шимт хөрсийг стандартын дагуу хуулж, хадгалах үйл ажиллагаанд хяналт тавих (шинээр хөрс хуулах тохиолдол бүр)

Хөшөөтийн нүүрсний уурхай нь Хөрс-Газарзүйн мужлалаар Говийн их муж, өндрийн бүсчлэлтэй Монгол Алтайн дэд мужийн Монгол Алтайн 51-р тойрогт хамаарах ба уурхайн эдэлбэр газрын хэмжээнд уулын болон хөндийн, нугын хөрс зонхилон тогтворжиж хөрсний 8 хэв шинж, дэд хэв шинж тархсан байдаг. Эдгээрээс элсэнцэр хар хүрэн хөрс тархсан хэсэгт уурхайн 2021-2025 оны үйл ажиллагаа явагдаж нийт 52.85 сая м³ хөрс хуулах төлөвлөгөөтэй. 2023 оны байдлаар уурхайн ашиглалт, отвалын үйл ажиллагааны зориулалттай 48 га талбайн шимт хөрс хуулж нийт 52,660.1 м³ буюу 63,198.16 тонн хөрсийг шинээр хуулж хадгалсан. Өөрөөр хэлбэл нийт 109,309.3м³ буюу 131,171.2 тонн шимт хөрсийг MNS 5916:2008 стандартын дагуу хадгалж байна. Нүүрсний орд газрын хэмжээнд хөрс хортой бодис, элементээр бохирдож доройтоогүй. Хөрсөнд агуулагдах хүнд


элементийн агууламж стандартын түвшинд байгаа эсэхийг тодорхойлж, хянаж байх зорилгоор улирал тутам хөрсний дээжийг шинжилгээнд хамруулан ажиллаж байна.



Зураг 16. Хуулсан шимт хөрс тээвэрлэлт



Зураг 17. Шимт хөрснөөс авч оффис орчимд ногоон байгууламж байгуулсан.



Зураг 18. 2023 онд хуулсан шимт хөрсний хэмжээ

2.10 Амьтны аймаг

1. Цаг хүндэрсэн үед уурхайн нөлөөллийн бүс дэх зэрлэг ан амьтанд биотехникийн арга хэмжээг авах

Тус ажлын хүрээнд Үенч, Дарви, Цэцэг сумдын нутаг дэвсгэрт хамаарах улсын болон орон нутгийн ТХГ нутагт 350 пресс өвс, 3 тонн хужир тавьж өгч биотехникийн арга хэмжээ авсан. Үүнд:

- Үенч сумын байгаль хамгаалагч, Говийн их дархан цаазат газрын “Б” хэсгийн байгаль хамгаалагч, Үенчийн тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагч нартай хамтарч 2023 оны 3 дугаар сарын 1-2-ны өдрүүдэд Говийн их дархан цаазат газрын “Б” хэсэгт цагаан зээр, хар сүүлт, хулан нутагладаг Жирэнтэйн хар, Шалын хоолой, Үенч сумын тусгай хамгаалалттай газар нутагт янгир ямаа нутаглаж үр төлөө гаргадаг Дэрстэйн барууны ам, Дэрстэйн хөндлөн гэх газруудад
- Дарви сумын Мөрөн багийн Засаг даргатай хамтарч 2023 оны 3 дугаар сарын 7-ны өдөр Хөшөөтийн хөндий өгсөж, Сутай хайрхан уул тусгай хамгаалалттай газар нутгаар янгир ямаа нутагладаг Хар асга, Дайчин ам, Шаварт нэртэй газруудад
- Цэцэг сумын нутагт буюу Мянган угалзатын нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч нартай хамтарч 2023 оны 3 дугаар сарын 4-ний өдөр аргаль нутагладаг газрууд болох Цахир хамар, Тасархай хар, Босго, Сөрт нэртэй газруудад хэрэгжүүлсэн.







Зураг 19. Зэрлэг ан амьтдад биотехникийн арга хэмжээ авч байгаа нь

2.11 Хуурай баяжуулах үйлдвэрийн тэжээлийн талбайд үүсэх тоосжилт бий болохоос сэргийлж тоос дарагч мананжуулагч машиныг үргэлжлүүлэн ашиглана.

Хуурай баяжуулах үйлдвэр, гаалийн хяналтын талбайн ачилтын талбайгаас үүсэх тоосны хэмжээг бууруулах сөрөг нөлөөллийг багасгах үүднээс 4 мананжуулагч машинаар мананжуулах усалгаа хийж байна. Мананжуулагч машин нь агаарт дэгдэх тоос руу усыг мананцар болгон өндөр даралтаар цацсанаар барьцалдуулан газарт буулгадаг ач холбогдолтой. 2023 онд зам талбайн тоосжилтыг бууруулахад 129996 шоо метр ус зарцуулсан байна.



Зураг 20. Нүүрсний талбайд ажиллаж байгаа мананжуулагч машин



Зураг 21. Хуурай баяжуулах үйлдвэр, экспортын нүүрс ачилт, буулгалтын талбай

ГУРАВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Нөхөн сэргээлтийн зориулалт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	Одоогоор нөхөн сэргээлт хийх талбай байхгүй.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүр	Одоогоор нөхөн сэргээлт хийх талбай байхгүй.	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт стандарт MNS_5914_2008
2	Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсний шинэ овоолгын үржил шимийг алдагдуулахгүй хадгалалтыг уртасгахын тулд ургамалжуулах ажлыг үргэлжлүүлэх, олон наст ургамлын туршилт хийх	4,625,000	Жил бүр	Уурхайн шимт хөрсний овоолгын үржил шимт байдлыг алдагдуулахгүй хадгалалтыг уртасгахын тулд ургамалжуулж олон наст тэжээлийн ургамал тариалсан Дэлгэрэнгүйг тус тайлангийн 3.1 дүгээр бүлгээс харна уу.	Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS_5916_2008
3		Уурхай орчмын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх мод тарих	Үйл ажиллагааны зардлаас	Жил бүр	Тус онд ажилчдын амрах байр, кемп орчмын ногоон байгууламжийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Засварын газар нүүлгэн шилжүүлсэнтэй холбоотой хуучин засварын газар орчимд ургаж байсан мод, суулгацыг шилжүүлэн суулгаж арчилж ургуулах ажил хийгдсэн. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 3.2 дүгээр бүлгээс харна уу.	MNS 6774:2019 Том мод, суулгацыг шилжүүлэн суулгах, арчлах. Техникийн шаардлага
4	Татан буулгах, хаалтад бэлтгэх	Одоогоор татан буулгах, хаалтад бэлтгэх талбай байхгүй.	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүр	Одоогоор татан буулгах, хаалтад бэлтгэх талбай байхгүй.	Байгаль орчны аудитын үл нийцлийг арилгах төлөвлөгөө
Нийт зардал, мян.төг			4,625.000			


3. Биологийн нөхөн сэргээлт

3.1 Шимт хөрсний шинэ овоолгын үржил шимийг алдагдуулахгүй хадгалалтыг уртасгахын тулд ургамалжуулах ажлыг үргэжлүүлэх, олон наст ургамалын туршилт хийх

Уурхайн шимт хөрсний талбайн үржил шимийг урт хугацаанд хадгалах зорилгоор ургамалжуулж Ботууль, Ерхөг, Өлөнгө, Дааган сүүл зэрэг олон наст ургамлыг үрээр тариалсан. Шимт хөрсний талбайгаас 2023 оны 7 дугаар сарын 24-нд дээж авч МХЕГ-ын ХАБҮЛ лабораторид цацрагийн шинжилгээнд хамруулсан. Шинжилгээгээр дээжийн үндсэн үзүүлэлтүүд бохирдолгүй хэвийн хэмжээнд байна гэж дүгнэгдсэн. 2023 онд уурхайн ашиглалт, отвалын үйл ажиллагааны зориулалттай 48 га талбайн 52,660.1 м³ буюу 63,198.16 тонн хөрсийг шинээр хуулж хадгалсан. Өөрөөр хэлбэл нийт 109,309.3м³ буюу 131,171.2 тонн шимт хөрсийг MNS 5916:2008 стандартын дагуу үржил шимийг алдагдуулахгүй байх арга хэмжээ авч, 5 метрээс өндөргүй байхаар тооцон тусгай талбайд овоолон хадгалж байна.



Зураг 22. Шимт хөрсний талбайд олон наст ургамалын үр тариалсан



Зураг 23. Шимт хөрсний талбайд хадгалагдаж байгаа шимт хөрсний хэмжээ

3.2 Уурхайн орчмын ногоон байгууламжыг нэмэгдүүлэх мод тарих

Тус онд ажилчдын амрах байр, кемп орчмын ногоон байгууламжийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Засварын газар нүүлгэн шилжүүлсэнтэй холбоотой хуучин засварын газрын ургаж байсан мод, суулгацыг шилжүүлэн суулгаж арчилж ургуулах ажил хийгдсэн.



Зураг 24. Засварын газрын ногоон байгууламж

ДӨРӨВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт	Хөндийн хэв эвдэрсэн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх /Аймгийн БОАЖГ-ын санал /	Алтай сум 2 га	13,000,000	Нэг удаа	Алтай сумын газар нутагт гар аргаар алт олборлох үйл ажиллагаанд өртөж эвдэрсэн Хөндийн хэвийн 2 га, Халтар уулын 1.5 га нийт 3.5 га газарт техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэхээр “Алтайн баян ундарга” ЗГБХН нөхөрлөлтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Халтар уулын 1.5 га газрын нөхөн сэргээлтийн ажлыг хийж дуусгасан. Хөндийн хэвийн 2 га газарт техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж 2023.11.20-нд дуусган аймгийн болон орон нутгийн холбогдох ажлын хэсэгт хүлээлгэж өгч акт үйлдсэн. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 4.3 дүгээр бүлгээс харна уу.	Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт стандарт MNS_5914_2008
2		Халтар уулын эвдэрсэн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх. /Аймгийн БОАЖГ-ын санал/	Алтай сум 1.5 га		Нэг удаа		
3		Бүрэнхайрханы эвдэрсэн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх. /Аймгийн БОАЖГ-ын санал/	Булган сум 2 га	6,453,264.52	Нэг удаа	Булган сумын нутаг дахь Бүрэн хайрханы 0.4 га эвдэрсэн газрын хонхор хотгорыг түрж тэгшлэх, хэлбэршүүлэх зэрэг техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж дуусгасан. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 4.2 дүгээр бүлгээс харна уу.	
4		Үрсийн цагаан толгой эвдэрсэн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх. /Аймгийн БОАЖГ-ын санал/	Булган сум 1 га		Нэг удаа		
5		Булган гол дагуу эвдэрсэн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх. /Аймгийн БОАЖГ-ын санал/	Булган сум 0.5 га	3,444,133.71	Нэг удаа	Булган гол дагуу хайрга олборлох зорилгоор ашиглаж байсан хуучин карьерийн газрын хонхор хотгорыг түрж тэгшлэх, хэлбэршүүлэх зэрэг 0.9 га газарт техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 4.2 дүгээр бүлгээс харна уу.	
6		Үенч сумын төвд эвдэрсэн 10 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	Үенч сум 10 га	58,709,306.25	Нэг удаа	2023.08.30-09.20 хүртэл нийт 21 хоногийн хугацаанд Үенч сумын нэгдсэн хогийн цэгийн 10 га газарт техникийн нөхөн сэргээлт хийж хур хог хаягдлыг овоолж хэлбэршүүлэх, ландфилдэх, зам талбай гаргах, 100м*60м харьцаатай 3м-ийн гүнтэй	

						хогийн цэг гаргаж ажилласан. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 4.1 дүгээр бүлгээс харна уу.	
7	Дүйцүүлэн хамгаалах нэмэлт ажил	Нэгдсэн хогийн цэгийн хог булшлах талбайг нэмэгдүүлж, тохижуулах	Дарви сум	26,940,033.46	Нэг удаа	Дарви сумын нэгдсэн хогийн цэгийн хог хаягдлыг цэвэрлэх, булшлах, ландфилл хийх, шинээр хогийн цэг ухаж байгуулах ажлыг хийж гүйцэтгэн сум орон нутагт хүлээлгэн өгсөн. Үүнд: 5,774.74 м ² талбайд газрын гадаргаас доош 3-4 метр гүн хонхор ухаж, шинээр хогийн цэг байгуулж, хуучин хогийн цэг болох 6,760.66 м ² талбайг булшилж хэлбэршүүлсэн. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 4.4 дүгээр бүлгээс харна уу.	Сумдаас ирүүлсэн санал
8		Булган сум Ендэртийн рашаан, Цэцэг сум Баянгол, Дарви сум Цагаан булаг, Үенч сум /булгийн эхийг хашиж хамгаалах/	Булган, Үенч, Цэцэг, Дарви, ҮББГСГЗ 5	33,060,890	Нэг удаа	Цэцэг сумын Баянгол багийн нутаг дахь Баянголын булаг, Дарви сумын Мөрөн багийн нутаг дахь Цагаан давааны булаг, Үенч сумын Цагаан түнгэ багийн Улаан-үзүүрийн булгийн эх, Булган сумын нутаг дахь Үенч Бодонч Булган голын сав газарт хамрагдах Ендэртийн рашааны эхийг тус бүр хашиж хамгаалан сум орон нутагт нь хүлээлгэн өгсөн. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 4.5 дүгээр бүлгээс харна уу.	Сумдаас ирүүлсэн санал
9		Говийн гайхамшигт 6 арга хэмжээг зохион байгуулах БОАЖГ-т санхүүгийн дэмжлэг үзүүлэх	Ховд аймгийн БОАЖГ 1	7,616,0000	Нэг удаа	Аймгийн БОАЖГ Говийн гайхамшигт 6 арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллахаар төлөвлөгөөнд тусгагдсан байсан хэдий ч тус арга хэмжээнд оролцох зардлыг тухайн байгууллага өөрсдөө шийдвэрлэж ажилласан бөгөөд манай байгууллагын зүгээс “Байгаль хамгаалагчдыг чадавхжуулах сургалт-2023” арга хэмжээнд дэмжлэг үзүүлсэн.	Ховд аймгийн БОАЖГ санал
10		Үенч Бодонч Булган голын сав газарт хамрагдах голуудад онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн тэмдэгжүүлэлт хийх.	Алтай, Үенч, булган сум 16	15,840,000	Нэг удаа	Усны сан бүхий газруудын Онцгой болон энгийн хамгаалалттай бүсийн тэмдэгжүүлэлт, мэдээллийн самбар 15 ширхгийг хийж Үенч Бодонч Булган голын сав газрын хамгаалалтын захиргаанд хүлээлгэн өгсөн. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 4.6 дүгээр бүлгээс харна уу.	Сумдаас ирүүлсэн санал

11		Гүний худаг гаргах	Дарви, Цэцэг сум 1	102,107,500	Нэг удаа	Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Дарви, Цэцэг сумдын нутагт малчид, ойжуулалт мод усалгаанд зориулсан гүний худгийг гаргаж, тохижуулах ажлыг мэргэжлийн байгууллага болох “Алтайн хар сувд” ХХК, “Сэжигтийн боргио” ХХК-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгэн сум орон нутагт хүлээлгэн өгсөн. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 4.8 дүгээр бүлгээс харна уу.	Сумдаас ирүүлсэн санал
12	Дүйцүүлэн хамгаалах урт хугацааны төлөвлөгөө	Сутай хайрхан УТХГ-ын мөстлөг, цасны судалгаагаар авиралт хийх	Дүйцүүлэн хамгаалах талбай 2	2,532,272	Тогтмол	Сутай хайрхан уулын авиралтыг МоЭнКо ХХК-ийн 2 ажилтан, хөтөч, Хүйсийн Говь-Цэцэг нуурын сав газрын захиргааны 4 албан хаагчтай хамтран жилд 2 удаа тус авиралтыг зохион байгуулсан. Тоосонцрын хэмжээг тодорхойлохоор тоосны хэмжилтийн Dusttruck багажийг PM2.5, PM10 хошуугаар 3 цэг авч хэмжилт хийсэн. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 4.7 дүгээр бүлгээс харна уу.	Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд
13		Өвөл, хаврын улиралд цаг хүндэрсэн тохиолдолд зэрлэг ан амьтанд био техникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх /Өвс, хужир, шүү/	Дүйцүүлэн хамгаалах талбай 3	12,550,000 /Сөрөг нөлөөллийг бууруулах зардалд орсон/	Тухай бүрд	Тус ажлын хүрээнд Үенч, Дарви, Цэцэг сумдын нутаг дэвсгэрт хамаарах улсын болон орон нутгийн ТХГ нутагт 350 пресс өвс, 3 тонн хужир тавьж өгч биотехникийн арга хэмжээ авч ажилласан. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 4.9 дүгээр бүлгээс харна уу.	Дүйцүүлэн хамгаалах урт хугацааны төлөвлөгөө
Нийт зардал, мян.төг						269,703,400	

4. Биологийн олон янз байдал дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний биелэлт

4.1 Үенч сумын төвд эвдэрсэн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх /Үенч сумын санал/

Үенч сумын нэгдсэн хогийн цэгт техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг 2023 оны 08.30-9.20-ны хооронд хийж гүйцэтгэсэн. Тус ажлын хүрээнд 100м*60м хэмжээтэй 3м-ийн гүнтэй нүх ухаж хогийн цэг гаргасан. Ухсан талбайгаас гарсан шороогоор хөмсөг татаж, хог хаягдлыг нэг цэгт бөөгнөрүүлэх талбайг шинээр гаргасан талбайтай залгуулан засаж бэлдсэн. Өөрөөр хэлбэл Үенч суманд хог хаягдал нэг цэгт төвлөрүүлэх хоёр талбайг засаж бэлдэн, хүлээлгэн өгсөн. Мөн ойр орчмын хог хаягдлыг түрж бөөгнүүлэх, овоолго үүсгэх гэх мэт ажлыг зохион байгууллаа. Дээрх ажлыг хийж дуусгахад норд-2, экскаватор-1, дозер-1, суудлын тэрэг-1 нийт 5 техник 6 хүн ажилласан.

Нэмэлтээр: Цэргийн ангийн хашаанд хуримтлагдсан нүүрс, үнсний хог хаягдлыг /28 норд хог/ зөөж хогийн нэгдсэн цэгт хүргэж ажилласан. Мөн сумын төвийн зам дагуу эвдэрсэн газруудыг засварлах, хөмсөг татах зэрэг ажлуудыг хийсэн.





Зураг 25. Үенч сумын нөхөн сэргээлт хийх газрын сансарын зураг




Зураг 26. Үенч сум 10 га техникийн нөхөн сэргээлт

4.2 Булган суманд эвдэрсэн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх /Аймгийн БОАЖГ-ын санал/

Булган сум, БОАЖГ-аас ирсэн саналын дагуу 2023.09.21-27 хүртэл 7 хоногийн хугацаанд Булган сумын нэгдсэн хогийн цэгийн талбай болох Үрсийн цагаан толгой гэх 2 га газарт тархсан хог хаягдлыг түрж овоолго үүсгэх, нэг цэгт төвлөрүүлэх, ландфилдэх арга хэмжээ авч техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн Булган сумын Бүрэнхайрханы эвдэрсэн 0,4 га, Булган гол дагуу хуучин ашиглаж байсан хайрганы карьерын 0,9 га газрыг тэгшлэх, нөхөн дүүргэх, гадаргууг хэлбэршүүлэх зэрэг техникийн нөхөн сэргээлтийн ажлыг шат дараатай хийж гүйцэтгэн сум орон нутагт хүлээлгэн өгч ажиллаа. Дээрх ажлыг хийж дуусгахад норд бенз-2, экскаватор-1, дозер-1, суудлын тэрэг-1 нийт 5 техник 6 хүн ажилласан.





Зураг 27. Булган сум Бүрэн хайрхан, Булган гол дагуу 1,3 га Үрсийн цагаан толгой /хогийн цэг/-2 га газарт техникийн нөхөн сэргээлт


4.3 Алтай суманд эвдэрсэн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх /Аймгийн БОАЖГ-ын санал/

Алтай сумын нутагт гар аргаар алт олборлох үйл ажиллагаанд өртөж эвдэрсэн Хөндийн хэвийн 2 га, Халтар уулын 1.5 га нийт 3.5 га газарт техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэхээр “Алтайн баян унадарга” ЗГБХН нөхөрлөлтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж байна. Халтар уулын 1.5 га газарын нөхөн сэргээлтийн ажлыг хийж дуусгасан. Хөндийн хэвийн 2 га газарт техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж, 2023.11.20-нд дуусган аймгийн БОАЖГ болон тухайн сумын ЗДТГ-т хүлээлгэн өгч ажилласан. 2023 оны байдлаар нийт 4.8 га газарт техникийн нөхөн сэргээлтийн ажил, 3 сумын 13.3 га газарт хогийн цэг гаргах, ландфилдэх, зам талбайг гаргах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн байна.





Зураг 28. Алтай сум Халтар уулын 1.5 га техникийн нөхөн сэргээлт



Зураг 29. Алтай сум эвдэрсэн газрын байршлын зураг

4.4 Дарви сумын нэгдсэн хогийн цэгт техникийн нөхөн сэргээлт хийх /Аймгийн БОАЖГ-ын санал/

Ховд аймгийн Дарви сумын нэгдсэн хогийн цэгт техникийн нөхөн сэргээлт хийх ажлыг хоёр үе шаттайгаар зохион байгуулж ажилласан. Тодруулбал:

Дарви сумын Засаг даргаас ирсэн хүсэлтийн дагуу 2022 оны 3 дугаар сарын 26-ний өдөр сумын төвийн нэгдсэн хогийн цэгт ковш техник ажиллуулж дараах ажлыг гүйцэтгэсэн. Үүнд:

- Нэгдсэн хогийн цэгт 1.5 га талбайд тарааж асгасан хог хаягдлын 60 орчим хувийг ландфиллийн талбайд түрж оруулсан.
- Тарааж асгасан хог хаягдлын үлдэгдэл 40 хувийг түрж нэгтгэн 2 овоолго үүсгэсэн.
- Ланфиллийн талбайн орох хэсгийг цэвэрлэн зам гаргаж, тарааж асгасан хог хаягдлыг дээш шууж хог асгах талбайг гаргасан.
- Ланфиллийн талбай руу орж хог хаягдлаа асгах зам талбайг түрж тэгшилсэн.

Дээрх арга хэмжээг зохион байгуулсны дараа нэгдсэн хогийн цэгийн хог хаягдлыг цэвэрлэх, булшлах, ландфилл хийх, шинээр хогийн цэг ухаж байгуулах ажлыг хийж гүйцэтгэн сум орон нутагт хүлээлгэн өглөө. Үүнд: 5,774.74 м² талбайд газрын гадаргаас доош 3-4 метр гүн ухаж шинээр хогийн цэг байгуулж, хуучин хогийн цэг болох 6,760.66 м² талбайг булшилж хэлбэршүүлсэн. Экскаватор-1, Ковш-1, Өөрөө буулгагч-2, трейлер-1, пекап-1 техникүүд нийт 11 хоног ажилласан. Тус ажлыг хийж гүйцэтгэхэд Алтайн зам ХК-иас техник гаргаж хамтран ажилласан.



Зураг 30. Дарви сум хогийн цэгийн нөхөн сэргээлт

4.5 Дарви, Цэцэг, Үенч, Булган сумдад тус бүр нэг булгийн эх хашиж хамгаалах

Цэцэг сумын Баянгол багийн нутаг дахь Баянголын булаг, Дарви сумын Мөрөн багийн нутаг дахь Цагаан давааны булаг, Үенч сумын Цагаан түнгэ багийн Улаан үзүүрийн булгийн эх, Булган сумын нутаг дахь Үенч Бодонч Булган голын сав газарт хамрагдах Ендэртийн рашааны эхийг тус

бүр хашиж хамгаалан сум орон нутагт нь хүлээлгэн өгсөн. Дээрх ажлыг хийж гүйцэтгэснээр 2023 оны байгаль орчныг хамгаалах менежмент төлөвлөгөөнд тусгагдсан нөлөөллийн бүсийн 4 суманд тус бүр нэг булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн байна. Тодруулбал:

- Дарви сумын Мөрөн багийн нутаг Цагаан давааны булгийн эхийн хашилт хамгаалалтыг сэргээн хамгаалалтын торон хашаа татаж ажиллаа. Тус булгийн эхийг хашиж хамгаалахад 34 метр тор, 14 ширхэг шон орсон бөгөөд 7 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан.
- Цэцэг сумын Баянгол багийн нутаг дахь Баянголын булгийн эхийг 2023.08 сарын 3-нд хашиж хамгааллаа. Булгийн эх хашиж хамгаалахад 120 м хүрээтэй тор, 34 ширхэг шон төмөр ашиглаж, 6 хүн ажилласан.
- 2023.08.23-24-ний хооронд Үенч сумын нутаг дахь Цагаан түнгэ багийн Улаан үзүүрийн булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг хийж гүйцэтгэсэн. Булгийн эх хамгаалахад 140м урттай 1152м² талбайд 4м урттай 36 ширхэг хүрээтэй тор, 40 ширхэг шон төмөр орсон ба 6 хүний бүрэлдэхүүнтэй 2 өдөр тус ажлыг хийж гүйцэтгэсэн.
- Ховд аймгийн Булган сумын Алаг толгой багийн нутаг, Үенч Бодонч Булган голын сав газрын захиргаанд хамрагдах Ендэртийн рашааны эхийг хашиж хамгаалан орон нутагт нь хүлээлгэн өгсөн. Булгийн эхийг хашиж хамгаалахад 140 метр урт хүрээтэй тор 40 ширхэг шон төмөр ашигласан байна.



Зураг 31. Дарви сум Мөрөн баг Цагаан давааны булаг сэргээж хамгаалсан байдал



Зураг 32. Булган сум Нарийн гол багт Байшинт адаг усны булаг хамгаалсан байдал



Зураг 33. Үенч сум Цагаан түнгэ багт Улаан үзүүрийн булаг хамгаалсан байдал



Зураг 34. Цэцэг сум Баянгол баг Баянголын булаг хамгаалсан байдал

4.6 Үенч Бодонч Булган голын сав газарт хамрагдах голуудад онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн тэмдэгжүүлэлт хийх.

Алтай, Үенч, Булган сум, Үенч Бодонч Булган голын сав газрын хамгаалалтын захиргаанаас ирүүлсэн саналын дагуу усны сан бүхий газруудын Онцгой болон энгийн хамгаалалттай бүсийн тэмдэгжүүлэлт, мэдээллийн самбар 15 ширхгийг хийж Үенч Бодонч Булган голын сав газрын хамгаалалтын захиргаанд акт үйлдэж хүлээлгэн өгсөн.



Зураг 35. Мэдээллийн самбар, тэмдэгжүүлэлт хүлээлгэн өгсөн байдал

4.7 Сутай хайрхан УТХГ-ын мөстлөг, цасны судалгаагаар авиралт хийх

Тус мониторинг судалгааны ажил нь анх 2021 оны 3-р сарын 25-ний өдөр МоЭнКо ХКК, “Монгол орны хүйтэн мандал судлалын төв” ТББ хамтран ажиллах гэрээ байгуулснаар энэхүү судалгааны ажил эхэлсэн. Судалгааны зорилго нь Хөшөөтийн уурхайн үйл ажиллагаа Сутай хайрхан уулын

мөнх цасанд сөрөг нөлөө үзүүлж байгаа эсэхийг судлах зорилготой. Судалгааны ажлын хүрээнд тоосонцрын хэмжээг тодорхойлохоор тоосны хэмжилтийн Dusttruck багажыг PM 2.5, PM 10 хошуугаар 3 цэг авч хэмжилт хийж байна

Сутай хайрхан уулын авиралтыг МоЭнКо ХХК-ийн 3 ажилтан, хөтөч, Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газрын захиргааны 4 албан хаагчтай хамтран 2 удаа зохион байгуулж ажиллаа. Байгаль цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан 1 удаагийн авиралтын ажил амжилтгүй болж мониторингийн цэгтээ хүрч хэмжилт хийж чадалгүй буцаж ирсэн.



Зураг 36. Сутай хайрхан УТХГ-ын мөстлөг, цасны судалгааны авиралт

4.8 Дүйцүүлэн хамгаалах талбайд худаг гаргах

Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд малчид, ойжуулалт мод усалгаанд зориулсан гүний 2 худгийг Дарви, Цэцэг сумдад тус бүр нэгийг гаргаж тохижуулах ажлыг мэргэжлийн байгууллага болох Алтайн хар сувд ХХК, Сэжигтийн боргио ХХК-тай гэрээ байгуулан хийж гүйцэтгэн, сум орон нутагт нь хүлээлгэн өгч ажиллаа.





Зураг 37. Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд гаргасан худаг

4.9 Өвөл, хаврын улиралд цаг хүндэрсэн тохиолдолд зэрлэг ан амьтанд биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх /Өвс, хужир, шүү/

Биотехникийн арга хэмжээ: Дарви сум, Сутай хайрхан уул улсын тусгай хамгаалалттай газар

Амьтны амьдрах орчин болон идэш тэжээлийн нөхцөлийг сайжруулахад чиглэгдсэн үйл ажиллагааг "биотехникийн арга хэмжээ" гэж хэлнэ.

Өөрөөр хэлбэл цас зуд, ган гачиг, байгалийн онц үзэгдэл гэх мэт бусад шалтгаанаас болж зэрлэг ан амьтан идэш тэжээл, усаар гачигдаж эрсдэлд орсон үед хоол тэжээл, өвс, хужир тавьж өгөх, хөлдсөн ус, булаг шандны мөсийг хагалж ус гаргаж өгөх гэх мэт арга хэмжээ авахыг хэлдэг. Тус ажлын хүрээнд Дарви сумын Мөрөн багийн Засаг даргатай хамтарч 2023 оны 3 дугаар сарын 7-ны өдөр Хөшөөтийн хөндий өгсөж Сутай хайрхан уулын тусгай хамгаалалттай газар нутгаар янгир ямаа нутагладаг Хар асга, Дайчин ам, Шаварт нэртэй газруудаар 100 пресс өвс, 1 тонн хужир тавьж өгч биотехникийн арга хэмжээ авч ажилласан. Үүнд:

- Сутай хайрхан уул улсын тусгай хамгаалалттай газар нутаг Хөшөөтийн хөндий Дайчин ам 40 пресс өвс, 0.4 тонн хужир
- Сутай хайрхан уул улсын тусгай хамгаалалттай газар нутаг Хөшөөтийн хөндий Шаварт 30 пресс өвс, 0.3 тонн хужир
- Сутай хайрхан уул улсын тусгай хамгаалалттай газар нутаг Хөшөөтийн хөндий Хар асга 30 пресс өвс, 0.3 тонн хужир



Зураг 38. Дарви сум зэрлэг ан амьтад биотехникийн арга хэмжээ

Биотехникийн арга хэмжээ: Цэцэг сум, Мянган Угалзтын нурууны байгалийн цогцолборт газар

Тус ажлын хүрээнд Мянган угалзтын нурууны байгалийн цогцолборт газар нутагт аргаль нутагладаг газрууд болох Цахир хамар, Тасархай хар, Босго, Сөрт нэртэй газруудад тусгай хамгаалалтын захиргааны байгаль хамгаалагч нартай хамтарч 100 пресс өвс, 1 тонн хужирыг 2023 оны 3 дугаар сарын 4-ний өдөр тавьж өгч биотехникийн арга хэмжээ авч ажилласан. Үүнд:

- Мянган угалзатын нурууны аргаль нутагладаг Цахир хамар нэртэй газарт 40 пресс өвс, 0.4 тонн хужир
- Мянган угалзатын нурууны аргаль нутагладаг Тасархай хар, Босго, Сөрт нэртэй газарт 60 пресс өвс, 0.6 тонн хужир



Зураг 39. Цэцэг сум зэрлэг ан амьтад биотехникийн арга хэмжээ

Биотехникийн арга хэмжээ Үенч сум, Говийн их дархан цаазат газар

Тус ажлын хүрээнд Үенч сумын байгаль хамгаалагч, Говийн их дархан цаазат газрын “Б” хэсгийн байгаль хамгаалагч, Үенч сумын тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагч нартай хамтарч 2023 оны 3 дугаар сарын 1, 2-ны өдрүүдэд 150 пресс өвс, 1 тонн хужир тавьж өгч биотехникийн арга хэмжээ авч ажилласан. Үүнд:

- Говийн их дархан цаазат газрын “Б” хэсэгт цагаан зээр, хар сүүлт, хулан нутагладаг Жирэнтэйн хар, Шалын хоолой гэх газруудад 100 пресс өвс, 0.5 тонн хужир
- Үенчийн тусгай хамгаалалттай газар нутагт янгир ямаа нутаглаж үр төлөө гаргадаг Дэрстэйн барууны ам, Дэрстэйн хөндлөн гэх газруудад 50 пресс өвс, 0.5 тонн хужир тавьсан.



Зураг 40. Үенч сум зэрлэг ан амьтад биотехникийн арга хэмжээ

ТАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Нөлөөлөлд өртөх иргэд	Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Малчин өрх	Нүүлгэн шилжүүлэлтийн 2-р ээлжийн ажил болох уурхайн нөлөөллийн бүсийн өвөлжөө хаваржааны нүүлгэн шилжүүлэлтийн ажлыг үргэлжлүүлэх	Нөлөөллийн сумдын малчин өрх	Тодорхойгүй	Төслийн тусгай санхүүжилт	2022-2023 онуудад нийт 128 малчин өрхөд тоосжилтийн нөхөн олговор олгох ажиллагаа зохион байгуулж байгаа бөгөөд 2022 онд олгогдох нөхөн олговрыг бүрэн олгосон. 2023 онд компаниас өгөх нөхөн олговрын зардлыг шийдвэрлэж ажилласан.	Байгаль орчин нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээ, Ховд аймаг болон МоЭнКо ХХК хоорондын хамтран ажиллах гэрээ
Нийт зардал мян.төг				-			


ЗУРГАА. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө Археологи Палеонтологийн судалгаа хийгдсэн	Археологийн судалгаагаар тогтоогдсон уурхай орчмын хиргисүүр болон булшнуудыг фото зургаар баримтжуулж бүртгэлжүүлэх	Хөшөөтийн нүүрсний уурхай орчим	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүр	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний хүрээнд 2010 онд Монгол улсын ШУА-ийн Археологийн авран хамгаалах хээрийн шинжилгээний багаар судалгаа хийлгэж бүртгэлжүүлсэн археологийн 114 тооны дурсгалаас Хөшөөт-111, Хөшөөт-112, Хөшөөт-113, Хөшөөт-114 дурсгалуудыг 2022, 2023 онуудад дахин бүртгэлжүүлж бүрэн бүтэн байдалд хяналт тавьж фото зураг дарж баримтжуулсан. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 6.1 дүгээр бүлгээс харна уу.	Байгаль орчин нийгэмд нөлөөллөх байдлын үнэлгээ
2	Түүхийн дурсгалт газрууд	Түүхийн дурсгалт газруудад тэмдэг тэмдэглэгээ, мэдээллийн самбар байршуулах- 3ш	Нөлөөллийн сум	5,290,000	Нэг удаа	Түүх соёлын өвийг хамгаалах, соёлын өвийн талаарх хууль, дүрэм журмыг сурталчилан таниулах зорилготой мэдээллийн самбарыг Дарви суманд 2 ширхэг, Үенч суманд 1 ширхэгийг тус бүр хийж хүлээлгэн өгсөн. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 6.2 дүгээр бүлгээс харна уу.	Байгаль орчин нийгэмд нөлөөллөх байдлын үнэлгээ
Нийт зардал мян.төг				5,290,000			

6.1 Археологийн судалгаагаар тогтоогдсон уурхай орчмын хиргисүүр болон булшнуудыг фото зургаар баримтжуулж бүртгэлжүүлэх

дурсгалаас Хөшөөт-111, Хөшөөт-112, Хөшөөт-113, Хөшөөт-114 дурсгалуудыг бүртгэлжүүлж фото зураг дарж баримтжуулсан. Мөн Хөшөөт-114 дурсгалыг хамгаалсан.

Хөшөөт-111. Хөшөөт 111: Дугуй хүрээтэй овгор дараастай хиргисүүр бий. Хүрээний хэмжээ 1600 см, голын овгор 1200 см. Зүүн талдаа 1100 см урт, 400 см өргөн дагуултай. Байршил: Хойд өргөрөгийн $46^{\circ}47'18.6''$, зүүн уртрагийн $93^{\circ}16'57.1''$ солбилцолд оршино.




2022 он



2023 он

Зураг 41. Дугуй хүрээтэй овгор дараастай хиргисүүр 2022-2023 он

Хөшөөт 112: Дугуй хүрээтэй нэг хиргисүүр байна. Хиргисүүрийн хүрээний голч 1700 см, голын овгор 850 см. Байршил: Хойд өргөрөгийн $46^{\circ}47'22.8''$, зүүн уртрагийн $93^{\circ}16'55.8''$ солбилцолд оршино.




2022 он



2023 он



Зураг 42. Дугуй хүрээтэй хиргисүүр 2022-2023 он

Хөшөөт 113: Хүрээгүй дугуй чулуун овоолго бүхий байгууламж бий. Хэмжээ 900см. Байршил: Хойд өргөрөгийн $46^{\circ}47'23.2''$, зүүн уртрагийн $93^{\circ}16'58.4''$ солбилцолд оршино.



Зураг 43. Хүрээгүй дугуй чулуун овоолго бүхий байгууламж 2022-2023 он

Хөшөөт 114: Дугуй хүрээтэй нэг хиргисүүр байна. Хүрээний голч 1300 см, голын овгор дараас 950 см хэмжээтэй. Байршил: Хойд өргөрөгийн $46^{\circ} 7'31.3''$, зүүн уртрагийн $93^{\circ}17'17.2''$ солбилцолд оршино




Зураг 44 Хүрээ, дагуул байгууламжгүй хиргисүүр 2022-2023 он



Зураг 45. Хөшөөт 114: Дугуй хүрээтэй нэг хиргисүүрийн харагдах байдал

6.2 Нөлөөллийн бүсийн сумдын түүхийн дурсгалт газруудад мэдээллийн самбар хийж хүлээлгэн өгөх

Дарви сумын түүх соёлын дурсгалт газруудад түүх соёлын өвийг хайрлан хамгаалахыг уриалсан, түүх соёлын өвийн унаган төрхийг алдагдуулахгүй байхыг анхааруулсан мэдээллийн 3м*2м-ийн харьцаатай самбар 2 ширхэг, түүхийн нэн ховор дурсгал болох Монголчууд бидний төрт улс Хүннү гүрний мөнх тэнгэрийн тамга Үенч сумын Нарийн гол багийн нутаг дэвсгэр “Харгайтын бэлчрийн хадны зураг бичээсийг улсын тусгай хамгаалалтад авсан тухай тогтоол болон соёлын өвийн хууль тогтоомжийг сурталчлан таниулсан хуулийн заалт бүхий мэдээллийг агуулсан 3м*2м-ийн харьцаатай самбар 1 ширхгийг хийж Дарви, Үенч сумдад хүлээлгэн өгч ажилласан.




Зураг 46. Түүхийн дурсгалт газар байрлуулах мэдээллийн самбар


ДОЛОО. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Болзошгүй аюул, осол нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Биелэлтийн шалгуур
1	Аюултай бодис асгарах	Химийн бодисын MSDS-д заасны дагуу хадгалах, асгаралт үүссэн онцгой үед хэрэглэх шингээгч материалыг зохих газруудад бэлэн байлгах	Нүүрсний чанарын лаборатори, төслийн талбайн шаардлагатай газруудад	0	Тухай бүр	Химийн бодисын агуулах болон лаборатори, засварын газарт асгаралт үүссэн онцгой үед хэрэглэх асгаралтаас хамгаалах иж бүрдлийг байрлуулсан. Үүнд <ul style="list-style-type: none"> ✓ Асгаралт үүссэн үед ашиглах тосгуур ✓ Асгаралт үүссэн талбайг хязгаарлагч хөвөн ✓ Үүссэн асгаралтыг шингээгч алчуур Дэлгэрэнгүйг тус тайлангийн 7.1 дүгээр бүлгээс харна уу.
2	Аливаа халдварт өвчин бохирдолоос сэргийлэх	Ариутгал халдваргүйтгэл хийх	Уурхайн хэмжээнд	Үйл ажиллагааны зардлаас	Улиралд 1 удаа	Ариутгал халдваргүйтгэл, шавьж, шавьжгүйтэл устгалын ажлыг мэргэжлийн байгууллага болох “Ховд Жүли” нөхөрлөлтэй кетрингийн үйлчилгээ үзүүлдэг гэрээт ААН гэрээ байгуулан уурхайн ажлын байрууд, ажилтнуудын амрах байр, нийтийн ариун цэврийн өрөө, угаалгын газар болон уурхайн бүх хэсэгт улиралд 1 удаагийн давтамжтай ариутгал халдваргүйжүүлэлтийг хийж байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 7.2 дугаар бүлгээс харна уу.
3	Химийн бодисын хадгалалтад хяналт тавих	Химийн хорт болон аюултай бодисын тооллого хийх	Нүүрсний чанарын лаборатори	Үйл ажиллагааны зардлаас	Улирал тутам	Ашиглах зөвшөөрөл бүхий 18 нэр төрлийн химийн бодисын тооллогыг сар тутам хийж бүртгэл хөтлөн ажиллаж байна. Хавсралт 2, 3
4	Химийн бодистой харьцдаг ажилчид	Агуулахад зориулалтын нүд угаах, гал унтраах анхан шатны багаж, хэрэгсэл, хор саармагжуулах бодис, уусмалыг байрлуулах	Нүүрсний чанарын лаборатори	Үйл ажиллагааны зардлаас	Багц	Химийн бодисын агуулахад гарч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх үүднээс онцгой үед ашиглах дараах хэрэслүүдийг байрлуулсан. Үүнд <ul style="list-style-type: none"> ✓ Нүд угаах цэг ✓ Галын хор /ABC 4кг нунтаг/ ✓ Анхны тусламжийн хайрцаг ✓ Тэмдэг тэмдэглэгээ, мэдээлэл Дэлгэрэнгүйг тус тайлангийн 7.3 дугаар бүлгээс харна уу.
5	Гал түймэр	Төслийн талбайн барилга байгууламжийн галын дүгнэлт гаргуулах, гал түймрээс сэргийлэх, эрсдэлийг бууруулах, галын хор болон самбар нэмж байрлуулах	Уурхайн талбай дахь бүх барилга байгууламжууд	75000	Жилийн турш	Уурхайн галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор галын самбар 1 ширхэг хийлгэж гэрээт компаниудын техник нэвтрэн ордог төв хаалганы үүдэнд байрлуулсан. Мөн ажилчдын амрах байр, засварын газарт 4 ширхэг галын сараа шинээр байрлуулсан. Төслийн талбайд гал түймэр гарахаас сэргийлэх, эрсдэлийг бууруулах үүднээс даралт унасан, ашигласан галын хоруудыг сольсон. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 7.4 дүгээр бүлгээс харна уу.
Нийт зардал мян.төг				75000		

7.Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

МоЭнКо ХХК нь Ховд аймгийн мэргэжлийн хяналтын газраар химийн бодисын агуулахын ажлын байранд дүгнэлт гаргуулсан. Химийн бодис хадгалах агуулах нь агааржуулалтын системтэй, галын аюулгүй ажиллагааны үед ашиглах багаж хэрэгсэл, ослын үед хэрэглэх хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангасан, байнгын харуул хамгаалалттай, химийн бодисын хор аюулын таних тэмдэглэгээг байрлуулсан байна. Энэхүү химийн бодисын агуулах нь химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулахын ерөнхий шаардлага MNS 6458:2014 стандартад тавигдах шаардлага хангасан гэж дүгнэсэн. Уурхайн ТЭЗҮ өөрчлөгдөж байгаатай холбоотой шинэ суурьшлын бүсэд 2024 онд баригдах лабораторийн химийн бодисын агуулахын зураг төслийг MNS 6458:2014 стандартын дагуу хийлгэх хүсэлтээ 2022.12.16 -нд “Татах хүч” компанид өгсөн. (Зураг-48) д харуулав.





Зураг 47. Шинээр баригдах химийн бодис хадгалах агуулахын барилгын тойм зураг

Манай компани “Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль”, “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ыг чанд баримтлан ажиллаж байна. Химийн бодис асгарсан тохиолдолд ашиглах багаж, хэрэгсэл, шингээгч материал, хувийн хамгаалах хэрэгслийг ажлын байранд байршуулж, ажилчдад ашиглах дадлыг эзэмшүүлэх, химийн бодисын хог хаягдлыг аюултай хог хаягдал устгах зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжид шилжүүлэх хүртэл түр хадгалах аюулгүй нөхцөлийг бүрдүүлэн, химийн хорт болон аюултай бодисын сав, баглаа боодлыг импортлогч руу нь буцаадаг. Мөн аврах зам, гарц, цугларах цэг, анхны тусламжийн хайрцаг, хэрэгслийн байршил, чиглэлийн заасан тэмдэглэгээ, аюулгүй ажиллагааны тэмдэг, тэмдэглэгээ болон шаардлагатай утасны жагсаалтыг нүдэнд ил харагдахуйцаар байрлуулсан.



Зураг 48. Химийн бодисын хадгалалт



Зураг 49. Лабораторийн шинжилгээний үйл явц

7.1 Химийн бодисын MSDS-д заасны дагуу хадгалах, асгаралт үүссэн онцгой үед хэрэглэх шингээгч материалыг зохих газруудад бэлэн байлгах

Химийн бодисын агуулахад асгаралт үүссэн онцгой нөхцөл байдалд хэрэглэх зорилгоор асгаралтаас хамгаалах иж бүрдлийг байрлуулсан. Үүнд

- ✓ Асгаралт үүссэн үед ашиглах тосгуур
- ✓ Асгаралт үүссэн талбайг хязгаарлагч хөвөн
- ✓ Үүссэн асгаралтыг шингээгч алчуур




Зураг 50. Химийн бодисын агуулахад байрлуулсан асгаралтаас хамгаалах иж бүрдэл

7.2 Ариутгал халдваргүйтгэл хийх

Ариутгал халдваргүйжүүлэлтийг хүний эрүүл мэнд болон хүнсний бүтээгдэхүүнд нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор мэргэжлийн байгууллагаар улиралд нэг удаа хийлгэдэг. “Ховд жули” ББН тусгай зөвшөөрөлтэй компанийн баг бүрэлдэхүүн ирж тусгай зориулалтын бодисоор ариутгал халдваргүйжүүлэлт, мэрэгчгүйтгэл, шавжгүйтгэлийг 6883 мкв талбайд хийсэн. Тодруулбал:

- Шавжгүйтгэлийг сууц, гэрүүдэд-1800м²
- Мэрэгчгүйтгэлийг агуулах, гал тогоо, бэлтгэлийн өрөө, гэрүүдэд- 880м²
- Мөн 250 хүний ор хөнжилд халдваргүйжүүлэлт, гадна бие засах газар, бохирын худаг, төвлөрсөн хогийн цэгүүдэд ариутгал халдваргүйжүүлэлтэд хамруулсан.





Зураг 51. Ариутгал халдваргүйжүүлэлт

7.3 Шатах тослох материалын тосох, зөөх савыг нэмэгдүүлэх

Нүүрсний чанарын лаборатори, Хуурай баяжуулах үйлдвэрийн засварын цех, засварын газруудад асгаралт үүсэхээс урьдчилан сэргийлж Асгаралтын иж бүрдэл байрлуулсан. Асгаралт үүссэн тохиолдолд дээрхи иж бүрдлийг түргэн шуурхай ашиглах зорилгоор бэлэн байлгаж байна. Мөн ашиглах тусгай зөвшөөрөлтэй химийн 18 төрлийн бодисыг ашигладаг бөгөөд тухайн жилд ашигласан бодисын хэмжээ, үлдэгдлийн мэдээллийг хавсралтаар оруулав.



Зураг 52. Асгаралтаас хамгаалах иж бүрдэл

7.4 Төслийн талбайд гал түймрээс сэргийлэх, эрсдлийг бууруулах, галын хор болон самбар нэмэж байрлуулах

Уурхайн галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор галын самбар 1 ширхэг хийлгэж гэрээт компаниудын техник нэвтрэн ордог төв хаалганы үүдэнд байрлуулсан. Мөн ажилчдын амрах байр, засварын газарт 4 ширхэг галын сараа шинээр байрлуулсан. Төслийн талбайд гал түймэр гарахаас сэргийлэх, эрсдэлийг бууруулах үүднээс даралт унасан, ашигласан галын хоруудыг шинээр сольж байрлуулсан. Мөн Баруун бүсийн төв Ховд аймгийн Онцгой байдлын газраар “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө”, Уул уурхайн аврах ангиар “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг жил бүр хянуулж батлуулдаг.

Найм. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хог хаягдлын менежментийн үндсэн зарчим

Хөшөөт төсөл аль болох бага хог хаягдал үүсгэх, дахин ашиглах эсвэл дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын сөрөг нөлөөллийг бууруулах, хог хаягдлыг байгаль орчинд аюулгүй арга технологиор устгах зарчмыг баримтлан зохицуулахыг зорьж ажилладаг. Хог хаягдлыг дараах үе шатаар явагддаг. Үүнд:

- Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь арилгах болон бууруулах
- Хаягдал бүтээгдэхүүнийг дахин ашиглах (хэрэв шаардлагатай бол сэргээн зассаны дараа)
- Хаягдал бүтээгдэхүүнийг дахин боловсруулах. Зөвхөн үүний дараа хог хаягдлыг устгах үйл ажиллагаа явагдана.

МоЭнКо ХХК-ийн хог хаягдлын менежментийн үндсэн зарчим нь дараах байдлаар тодорхойлогдоно.



Схем. Хог хаягдлын менежментийн үндсэн зарчим

Хог хаягдлын ангилан ялгалт

Хог хаягдлын менежментийг үр ашигтай явуулахад хог хаягдлын ангилан ялгалт нэн чухал бөгөөд хаягдлыг зайлуулах тохиромжтой зөв арга замыг тогтоож өгдөг. Ангилан ялгалтын хог хаягдлыг эх үүсвэр дээр ба хог хаягдлыг хүлээн авах нэгдсэн цэг дээр явуулдаг. Үүнд:

Хоёрдогч түүхий эд болгон ашиглах боломжтой хог хаягдал

Хуванцар /ус, ундаа, кетчуп, ургамлын тос, бие угаагч шингэн, шампунь, угаалгын шингэний хуванцар сав/

- Хаягдал төмөр
- Бусад хог хаягдал
- Нүүрсний үнс
- Түргэн муудах хоол, хүнсний хаягдал
- Ариун цэврийн хаягдал
- Цай, кофены уут
- Сав баглаа, боодол
- Шил, лааз
- Гялгар уут
- Модон эдлэлийн хаягдал
- Хаягдал дугуй
- Резин / хаймар

- Барилгын хаягдал (тоосго, бетон, мод, тусгаарлагч болон дулаалгын материал, хадаас, цахилгааны монтаж, сантехникийн тоног төхөөрөмж, арматур, хаягдал, плита, ханын цаас зэрэг барилгын материалаас гадна суурийн шороо, огтолсон мод, чулуу зэрэг барилгын бэлтгэл ажлын явцад үүссэн хог хаягдлыг багтаана).

Аюултай хог хаягдал

Техник тоног төхөөрөмжийн засвараас гарах хаягдал (ашигласан тос, масло, антифриз)

Техникийн тос материалаар бохирдсон шингээгч материал, алчуур, тосны шүүр

Түлш, техникийн тосоор бохирдсон хөрс

Нүүрсний химийн лабораториос гарах шингэн хаягдал

Эмнэлгийн хог хаягдал

Эрүүлийг хамгаалах үйл ажиллагааны явцад үүсдэг хэрэглэгдсэн тариур, тариурын зүү, дуслын систем, хэрэгсэл, бохирдсон боолт, биеийн хэсэг, оношилгооны дээж, цус, химийн бодис, эм, эмнэлгийн багаж, цацраг идэвхт материалыг багтаана.

Түр хадгалалт, тээвэрлэлт

Хог хаягдлыг тухайн үүссэн цэг дээр нь хаягжуулалт бүхий тусгай цэгт битүү хогийн савнуудад ангилан ялгасан төрлөөр нь тусад нь хадгалах ба тээвэрлэлтийг эрх бүхий байгууллага тодорхой хуваарийн дагуу холбогдох журам стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.

Хогийн цэгийн үйл ажиллагаа

Хог хаягдлын нэгдсэн цэг дээр дараах үндсэн үйл ажиллагаа явагддаг.

Хогийн төвлөрсөн цэг дээр эх үүсвэр дээрээ ангилагдаагүй хог хаягдлыг дахин ангилан ялгах,

Ангилан ялгасан хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэх

Дахин ашиглагдах хог хаягдлыг ялгаж ангилсны дараа дахин ашиглах боломжгүй үлдсэн хог хаягдлыг шатаах зууханд шатаах

Шатаах зуухнаас гарсан үнс нурмыг булж устгах.

Ахуйн хог хаягдлын урсгал ба зохицуулалт

Төслийн үйл ажиллагааны хог хаягдлын менежментийн дагуу эх үүсвэрээс гарсан хог хаягдлын төрөл тус бүрд нийцсэн байгаль орчинд нөлөөлөл багатайгаар зайлуулах арга замыг сонгож хэрэгжүүлдэг.

Хүснэгт 10. Ахуйн хог хаягдлын төрөл ба зохицуулалт

Хог хаягдлын төрөл	Эх үүсвэр	Түр хадгалалтын нөхцөл	Хогийг цуглуулах болон зайлуулах явц	Тайлбар
Ахуйн хатуу хог хаягдал				
Ахуйн нийтлэг хог хаягдал	Ажилчдын кемпүүд, оффис	Хаягжуулсан саванд	Хог хаягдлыг ангилан ялгах, булшлах	Эрх бүхий ААН болон хувь хүмүүст өгөх
Цаасны хаягдал	Ажилчдын хотхон, Оффисууд,	Хаягжуулсан саванд	Дахин ашиглах, боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	
Хуванцар сав	Ажилчдын хотхон, Оффисууд	Хаягжуулсан саванд	Дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	
Ахуйн шингэн хаягдал				
Бохир ус	Ажилчдын хотхон, оффисууд	Зориулалтын танк	Ховд аймгийн цэвэрлэх байгууламж руу зөөх	Одоогоор цэвэрлэх байгууламж баригдаагүй тул зөөвөрлөж байна.

Хоолны үлдэгдэл	Хоолны газар	Хаягжуулсан саванд	Хоолны үлдэгдлийг нутгийн иргэдэд нохой, гахайн тэжээл болгон өгөх	Илүүдэл хаягдлыг булшилж устгах
Үйлдвэрлэлийн хатуу хаягдал				
Барилгын хаягдал	Барилга баригдсан талбай	Барилгын талбайд	Булшилж устгах	-
Хаягдал дугуйнууд	Засварын төв, Автопарк	Тусгай талбайд	Дахин ашиглах, Дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх,	Замын хаалт, тэмдгийн сууриар ашиглах
Поошиг	Уурхайн засварын төв	Тусгай талбайд	Цэвэрлээд хогийн сав болон хашааны материалд дахин ашиглах,	Замын тэмдгийн сууриар ашиглах
Төмөр	Төслийн нэгжүүд	Дахин ашиглах хаягдал цуглуулах цэгт	Дахин боловсруулах зорилгоор зах зээлд нийлүүлэх	Дахин боловсруулах компани болон хувь хүмүүст өгөх
Модон материалын хаягдал	Төслийн нийт нэгжүүдэд	Дахин ашиглах хаягдал цуглуулах цэгт	Дахин ашиглуулах зорилгоор нийлүүлэх	Орон нутгийн иргэдийн хэрэгцээнд өгөх

Аюултай хог хаягдлын хадгалалт, зохицуулалт

Химийн хорт болон аюултай бодисын хаягдлыг аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх тайлагнах журмын дагуу ангилан ялгаж эх үүсвэр дээр нь 90-180 хоног хадгалдаг. Эх үүсвэр дээр нь хадгалах хугацаа дуусахад аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий ААН-д гэрээ байгуулан, акт үйлдэж хүлээлгэн өгнө. Энэхүү журмын дагуу аймгийн БОАЖ-ын газраас аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэлийн дугаар авч хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хадгалах арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хүснэгт 11. Аюултай хог хаягдлын төрөл ба зохицуулалт


Хог хаягдлын төрөл	Эх үүсвэр	Хадгалалтын нөхцөл	Хогийг цуглуулах болон зайлуулах явц	Тайлбар
Тосоор бохирдсон хаягдал даавуу алчуурууд, төрөл бүрийн тосны шүүр	Засварын төвүүд	Хаягжуулсан саванд	Зориулалтын шатаах зууханд устгах	Шатаалтын Үнсийг булшлах, төмрийг ангилан ялгах
Тос, тосолгооны материал	Үйлдвэр, засварын төв	Зориулалт-ын танканд	Дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Эрх бүхий ААН ба компанид
Аккумулятор	Засварын төвүүд	Тусгай талбайд	Худалдан авагч талд нийлүүлэх	-
Химийн бодисын хаягдал, сав баглаа	Угаалга, лаборатори	Бодисын агуулах	Бодисын агуулах, тусгай талбайд хадгална	Холбогдох хууль, журмын дагуу
Үнс	Цахилгаан станц	Нэгдсэн бункерийн систем	Булшилж устгах, Барилгын материалд ашиглах	-

Эмнэлгийн хаягдал	хог	Анхны тусламжийн нэгж	Тусгай тур хогийн сав	Цэцэг сум	Зориулалтын дагуу хадгалах
-------------------	-----	-----------------------	-----------------------	-----------	----------------------------



Зураг 53. Аюултай хаягдлын ангилан ялгалт

ХӨШӨӨТ ТӨСЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС ГАРЧ БУЙ ХОГ ХАЯГДЛЫН ТӨРЛҮҮД, ЗАЙЛУУЛЖ БУЙ АРГА ЗАМ



НАЙМ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль, журам, стандарт
1	Ахуйн	Зам талбайд хийсч тарсан хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах	Төслийн талбай	Үйл ажиллагааны зардлаас	Улиралд	Уурхай орчмын хог хаягдлын цэвэрлэгээ, бүх нийтийн их цэвэрлэгээ, нүүрс тээврийн зам дагуу хог хаягдлын цэвэрлэгээг тогтмол хийж байна. Бүх нийтийн цэвэрлэгээг 1 удаа, орчны хог хаягдлын цэвэрлэгээг 7 хоногт 1 удаа, уурхайн ойр орчмын уст цэгүүдийн эх орчмын цэвэрлэгээг 4 удаа хийж гүйцэтгэсэн. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 8.1 дүгээр бүлгээс харна уу.	Хог хаягдлын тухай хууль
2		Хогийн цэг байгуулж хогийн сав байрлуулах /том хэмжээний засварын газарт байрлуулах/	Засварын газар, ажилчдын оффис	10,800,000	1 удаа	Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах үүднээс оффисын болон кемпийн өрөөнүүдэд 3 төрлөөр ангилан ялгах зориулалт бүхий хогийн хуванцар сав байрлуулж ангилан ялгаж байна. Үүнд -PLASTIC Хуванцар, Гялгар уут /ус, ундааны сав, бүх төрлийн гялгар уут/ -PAPER Цаас /бичгийн цаас, кардон бүх төрлийн цаасны хаягдал/ -NON RECYCLABLE Бусад хог /дахин ашиглах боломжгүй бусад хаягдал/ Мөн ангилан ялгалтын 3м урттай, 2 м өргөнтэй, 1,8 м өндөртэй том хэмжээтэй төмөр сав 2 ширхэгийг хийлгэж уурхайн оффис, засварын газарт байрлуулахаар захиалга өгч ажиллаж байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 8.1.1 дүгээр бүлгээс харна уу.	Хог хаягдлын тухай хууль
3		Уурхайгаас гарч байгаа шингэн хаягдалыг Ховд аймгийн цэвэрлэх	Төслийн талбай	Үйл ажиллагааны зардлаас	Тогтмол	Ажилчдын амрах байр, уурхайн оффисын цэвэрлэх байгууламжуудаас шингэн хаягдлыг бохирын машинаар соруулж Ховд аймгийн төв цэвэрлэх байгууламж руу тээвэрлэн хүргэдэг. 2023.10.05 өдрийн	

		байгууламж руу тээвэрлэх				байдлаар 945.08 тн шингэн хаягдлыг тээвэрлэн хүргэсэн байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 8.1.2 дүгээр бүлгээс харна уу.	
4		Хуванцар хог хаягдлыг шахаж нягтаршуулах пресслэгч машин худалдаж авах, ангилан ялгасан хуванцар савыг түүхий эд авах цэгт хүргэх	Төслийн талбай	4,200,000	Тогтмол	Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах, овор хэмжээг багасгах үүднээс хуванцар сав ангилан ялгах хадгалах цэг бэлдэж хүндлэл кемп, уурхайн оффис, засварын газарт байрлуулсан. 2023 онд 3 машин хуванцар хаягдлыг пресслэгч машинаар пресслүүлэхээр аймгийн Хот тохижилт ТӨҮК-г хүлээлгэн өгсөн. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 8.1.3 дүгээр бүлгээс харна уу.	Хог хаягдлын тухай хууль Аймгийн БОАЖГ-ын санал
5	Үйлдвэрийн	Гэрээт байгууллагаар нүүрс тээврийн 311 км зам дагуух хог хаягдлын цэвэрлэгээг хийлгэх, гэрээ байгуулах	Нүүрс тээврийн зам дагуу	36,000,000	Тухай бүр	Уурхайн нүүрс тээврийн 311 км зам дагуух хог хаягдлыг цэвэрлэх, ангилан ялгах, хогийн нэгдсэн цэг рүү тээвэрлэх үйл ажиллагааг сард 2 удаа хийхээр цэвэрлэгээ үйлчилгээний “Цэвэр хот өнгөт ирээдүй” ХХК-тай гэрээ байгуулан хяналт тавьж ажиллаж байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 8.2.1 дугаар бүлгээс харна уу.	Хог хаягдлын тухай хууль
6		Үйлдвэрийн болон барилга байгууламжаас гарах хаягдалыг устгах, хяналт тавьж ажиллах	Уурхайн талбай	Үйл ажиллагааны зардлаас	Тогтмол	Тус онд хийгдсэн барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэхдээ аль болох хог хаягдал үүсгэхгүй үлдэгдэл материалыг дахин ашиглах зарчмыг баримталж цаашид дахин ашиглах боломжтой материалуудыг хураан хадгалсан. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 8.2.2 дугаар бүлгээс харна уу.	Хог хаягдлын тухай хууль
7	Аюултай	Аюултай хог хаягдлыг ангилан ялгах сургалт сурталчилгааг ажилчдад өгөх	Уурхайн талбай	Үйл ажиллагааны зардлаас	Тогтмол	2023 оны 04 сарын 10-аас 05 сарын 10-нийг хүртэлх 1 сарын хугацаанд экспортын нүүрс тээврийн 26 компанийн 816 жолоочид тээврийн зам дагуух хог хаягдлын эх үүсвэр ангилан ялгалтын талаарх сургалт орж мэдээлэл өгсөн. Мөн засварын газрын ажилчид, болон кетринг компанийн үйлчилгээний ажилтнуудад оффис, амрах байрнуудаас гарч байгаа ахуйн хэрэглээний хог хаягдлыг ангилан ялгах тухай сургалт	Хог хаягдлын тухай хууль, Аюултай хог хаягдалын тухай журам

						орсон. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 8.3.3 дугаар бүлгээс харна уу.	
8	Аюултай	Уурхайн эмнэлгийн гаралтай хог хаягдлыг Цэцэг сумын эмнэлэгт хүргүүлж журмын дагуу устгах	Уурхайн талбай	Үйл ажиллагааны зардлаас	Тухай бүр	Уурхайн эмнэлгийн үйл ажиллагаанаас гарсан эмнэлгийн аюултай хог хаягдлыг Цэцэг сумын хүн эмнэлэгтэй байгуулсан гэрээний дагуу Цэцэг суманд хүргэж устгуулж байна. 2023 оны 10 сарын 31-ны өдрийн байдлаар 111,6 кг эмнэлгийн гаралтай хог хаягдлыг устгуулсан байна. Үүнд <ul style="list-style-type: none"> ✓ Халдвартай хог хаягдал-71,56 кг ✓ Хурц үзүүртэй иртэй хог хаягдал-39,5 кг (Эмнэлгийн гаралтай хог хаягдлын төлбөр 1,000,000 төгрөг) Дэлгэрэнгүйг тус тайлангийн 8.3.1 дүгээр бүлгээс харна уу.	Хог хаягдлын тухай хууль
9		Засварын газраас гарах ашигласан тосыг хуримтлуулж хадгалахад хяналт тавих	Уурхайн талбай	Зардал гарахгүй	Тухай бүр	Засварын газраас гарч буй ашигласан тосыг 20 тоннын багтаамжтай 2 ёмкост хадгалж хяналт тавьж ажиллаж байна. Цаашид аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй ААН-тэй хамтран ажиллах гэрээ байгуулахаар үнийн санал авах ажлыг зохион байгуулж байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн хавсралт 8.3.2 дугаар бүлгээс харна уу.	
10		Төслийн хүрээнд ашигласан аккумулятор, батерейг цуглуулан ангилан ялгаж хадгалах	Уурхайн талбай	Зардал гарахгүй	Тухай бүр	Төслийн хүрээнд уурхайн үйл ажиллагаанаас гарсан батарей, ашигласан аккумуляторыг төрөл төрлөөр нь ангилан ялгаж бүртгэл үүсгэн хадгалж байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 8.3.2 дугаар бүлгээс харна уу.	
Нийт зардал, мян.төг				51,000,000			

8.1 Ахуйн хог хаягдал

Зам талбайд хийсч гарсан хог хаягдлын цэвэрлэгээ зохион байгуулах

Уурхай орчмын хог хаягдлын цэвэрлэгээ, бүх нийтийн их цэвэрлэгээ, нүүрс тээврийн зам дагуу хог хаягдлын цэвэрлэгээг тогтмол хийж байна. Бүх нийтийн цэвэрлэгээ 1 удаа, орчны хог хаягдлын цэвэрлэгээ 7 хоногт 1 удаа, нүүрс тээврийн зам дагуух цэвэрлэгээ сард 2 удаа, уурхайн ойр орчмын уст цэгүүдийн цэвэрлэгээг 6 удаа зохион байгуулсан байна. Тодруулбал: “ХОГГҮЙ ЦЭЦЭГ” аяны хүрээнд 2023.04.04-05-ны өдрүүдэд бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулсан. Тус аяны хүрээнд Хөшөөтийн уурхай МоЭнКо ХХК, туслан гүйцэтгэгч гэрээт компаниуд Алтайн зам ХК, Мезом ХХК, Нүүрс тээврийн компаниуд 2 хоног оролцож нүүрс тээврийн зам дагуу болон өөрсдийн байрладаг кемп орчимд их цэвэрлэгээ зохион байгуулсан. Мөн Цэцэг суманд техникийн туслалцаа үзүүлж хамтарч ажилласан. Үүнд:

2023.04.04-ны өдөр

- Цэвэрлэгээ хийгдсэн талбай: Нүүрс тээврийн зам дагуу Бамбагарын үзүүрээс Шар кемп
- Ажилласан техник: Дугуйт ачигч /Ковш/, Автосамосвал /howo/, Трайллер, Бекаб, Автобус
- Хог хаягдлын хэмжээ: 210 шуудай, 2 автосамосвал

2023.04.05-ны өдөр

- Цэвэрлэгээ хийгдсэн талбай: Нүүрс тээврийн зам дагуу Шар кемпээс Моннис салдаг болон кемп орчмын дотор, гадна талбай
- Ажилласан техник: Дугуйт ачигч /Ковш/, Автосамосвал /howo/, Трайллер, Бекаб, Автобус
- Хог хаягдлын хэмжээ: 280 шуудай, 3 портер, 1 автосамосвал



Зураг 54. Хог хаягдлын нийтийн цэвэрлэгээ

8.1.1 Оффисын болон кемпийн өрөөнүүдэд хуванцар сав хадгалах хогийн савыг нэмэгдүүлэх

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах үүднээс оффисын болон кемпийн өрөөнүүдэд 3 төрлөөр ангилан ялгах зориулалт бүхий хогийн сав байрлуулж ангилан ялгаж байна. Үүнд

- PLASTIC Хуванцар, Гялгар уут /ус, ундааны сав, бүх төрлийн гялгар уут/
- PAPER Цаас /бичгийн цаас, кардон бүх төрлийн ццасны хаягдал/
- NON RECYCLABLE Бусад хог /дахин ашиглах боломжгүй бусад хаягдал

Мөн ангилан ялгалтын 3м урттай, 2 м өргөнтэй, 1,8 м өндөртэй том хэмжээтэй төмөр сав 2 ширхэгийг хийж уурхайн оффис, засварын газарт байрлуулахаар захиалга өгч ажиллаж байна.



Зураг 55. Уурхайн ахуйн хог хаягдлын ангилан ялгалт

8.1.2 Уурхайгаас гарч байгаа шингэн хаягдлыг Ховд аймгийн цэвэрлэх байгууламж руу тээвэрлэх

Бохир ус цэвэрлэх байгууламжийн тодорхойлолт:

Хүндлэл кемп нь 50-300 хүний бохир ус цэвэрлэх байгууламжтай. Бохир ус цэвэрлэх байгууламж нь байгаль орчинд ямар нэгэн хор нөлөөгүй.

Ахуйн бохир усыг урсгахгүйгээр цооногтоо боловсруулах боломжтой ус цэвэршүүлэх төхөөрөмж юм. Цэвэрлэх байгууламж руу урсаж орсон бохир усыг хүчилтөрөгчгүй орчинд боловсруулсны дараа хөрсний боловсруулах төхөөрөмж рүү илгээгдэж хөрсний бичил биетээр хүчилтөрөгчтэй орчинд амьдрах чадвартай задралыг явуулна. Тус байгууламжийг цахилгаангүй газарт суурилуулах боломжтой. Байгалийн шалгарсан цэвэршүүлэх чадварыг бүрэн ашигладаг систем учраас ердийн ажиллагааны аргатай харьцуулахад засвар үйлчилгээний зардал болон ажиллагааны ачаалал багатай. Цэвэрлэх процесст ашиглагддаг нэвчүүлэн цэвэршүүлэх материалтай

хатуу хаалт болон ус нэвтрүүлдэггүй хучилгат бокс зэрэг хөрсний даралтанд нилээд уян хатан шинж чанартай бат бөх болно. Мөн хүчиллэг, шүлтлэг шинж чанарт тэсвэртэй бөгөөд зэврэлтээс хамгаалах шинж чанартай тул байнгын хэрэглээ болгох боломжтой.

Тус байгууламж нь дараах 3 хэсгээс бүрдэнэ.

- Анхны ялган боловсруулах хэсэг
- 2-р ялган боловсруулах хэсэг
- Шүүх хэсэг

Ялган боловсруулах танкны систем нь хөрсний байгалийн цэвэршүүлэх чадварыг дээд зэргээр ашигладаг ус дахин ашиглах боломжтойгоор цэвэршүүлэх систем юм. Ялган боловсруулах төхөөрөмжид оруулсан бохир усыг хүчилтөрөгчгүй орчинд боловсруулсны дараа хөрс боловсруулах төхөөрөмж рүү илгээх бөгөөд хөрсний бичил биетээр хүчилтөрөгчтэй орчинд амьдрах чадвартай задралыг явуулдаг.

Уурхайн ахуйн бохир усыг зориулалтын бохир ус соруулдаг 20 тоннын 2 ширхэг автоцистерн машинаар соруулж Ховд аймгийн цэвэрлэх байгууламж руу хүргэдэг. 2023.10.05 өдрийн байдлаар 945.8 тн шингэн хаягдлыг тээвэрлэн хүргэсэн байна.



Зураг 56. Бохирын машин

8.1.3 Усны хуванцар савыг цуглуулах, тээвэрлэх, дахин ашиглах эрх бүхий мэргэжлийн байгууллагад нийлүүлэх

Хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах, овор хэмжээг багасгах үүднээс хуванцар сав ангилан ялгах хадгалах цэг бэлдэж хүндлэл кемп, уурхайн оффисс, засварын газарт байрлуулсан. 2023 онд 3 машин хуванцар хаягдлыг пресслэгч машинаар пресслүүлэхээр аймгийн БОАЖГ-т хүлээлгэн өгсөн. Мөн уурхайн үйл ажиллагаанаас гарч буй хуванцар савнуудыг аймгийн төврүү зөөж пресслүүлэх ажиллагааг хялбарчилах зорилгоор 2023 оны төсөвт хуванцар сав пресслэгч машин худалдан авах захиалга өгч худалдан авалтыг хийсэн.



Зураг 57. Хуванцар сав ангилан ялгалт

8.2 ҮЙЛДВЭРИЙН ХОГ ХАЯГДАЛ

8.2.1 Гэрээт байгууллагаар нүүрс тээврийн 311 км зам дагуух хог хаягдлын цэвэрлэгээг хийлгэх

Тээврийн 311 км зам дагуу замын 2 талаар 50 метр газарт хаягдсан хог хаягдлыг сард 2 удаагийн давтамжтай цэвэрлүүлж хяналт тавьж ажиллаж байхаар “Цэвэр хот өнгөт ирээдүй” ХХК тай хамтран ажиллах 9 сарын хугацаатай гэрээ байгуулан ажиллаж байна. Нүүрс тээврийн зам дагуух цэвэрлэгээг хийхэд хуванцар сав, хаягдал дугуй, олгой хаймар, архи пивоны шил сав, тос маслоны хуванцар сав гэх мэт хог хаягдал ихэвчлэн гардаг. Түүж цэвэрлэсэн хог хаягдлыг ойролцоох сумын хогийн нэгдсэн цэгт хүргэж буулгадаг. Зам дагуух цэвэрлэгээ хийх явцын зурган тайлангаа он сартай авч баталгаажуулан уурхайн БО-ны багт илгээж, сар бүрийн 10-аас өмнө өмнөх сарын тайлан бичиж ирүүлснээр төлбөр тооцоог хийж ажилласан.



Зураг 58. Нүүрс тээврийн зам дагуух хог хаягдлын цэвэрлэгээ

8.2.2 Барилга байгууламжаас гарах хаягдалыг устгах, хяналт тавьж ажиллах

Тус онд хийгдсэн барилга байгууламжийн ажлыг гүйцэтгэхдээ аль болох хог хаягдал үүсгэхгүй үлдэгдэл материалыг дахин ашиглах зарчмыг баримталж цаашид дахин ашиглах боломжтой материалуудыг хураан хадгалсан. Зарим ашиглагдахгүй материалыг хогийн цэгт хүргэж хаясан.



Зураг 59. Дахин ашиглах боломжтой барилгын хог хаягдлыг дахин ашиглаж байна

8.3 АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ

8.3.1 Уурхайн эмнэлгийн гаралтай хог хаягдлыг Цэцэг сумын эмнэлэгт хүргүүлж журмын дагуу устгах

Уурхайн эмнэлгийн үйл ажиллагаанаас гарсан эмнэлгийн аюултай хог хаягдлыг Цэцэг сумын хүн эмнэлэгтэй байгуулсан гэрээний дагуу Цэцэг суманд хүргэж устгуулж байна. 2023 оны 10 сарын 31-ны өдрийн байдлаар 111.06 кг эмнэлгийн гаралтай хог хаягдлыг устгуулсан. Үүнд

- Халдвартай хог хаягдал-71.56 кг
- Хурц үзүүртэй, иртэй хог хаягдал-39.5 кг

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны
өдрийн А/Б11 дүгээр тушаалын арваннэгдүгээр хэсгээр
Эрүүл мэндийн бүртгэлийн маягт СТ-29

ТУСГАЙ ХОГ ХАЯГДЛЫН БҮРТГЭЛ

Он 2023 сар

№	Хог хаягдлын ангилал Он сар өдөр	Халуурын зорилго эндөгтэй хог хаягдал	Хайвастай хог хаягдал	Хурц үеүртэй ирмэлтэй хог хаягдал	Сүмэг хог хаягдал	Эм, химийн бодис, эсд жортой хог хаягдал	Даралтат сав	Цацраг ирээдүй хог хаягдал	Хүнд металлын хог хаягдал	Дэвсгэр болж суурах хог хаягдал	Хог хаягдал хүргэлтэн лөгсөн хүний гарын үсэг	Хог хаягдал хүргэлтэн засаагүй хүний гарын үсэг
1	2023.01.13		5м 3м								М.Уугармаа	Ч.Ариунзори
2	2023.01.24		1м 0.5м								Б.Билэвчигэл	Б.Билэвчигэл
3	2023.02.03		3м 3.5м								М.Уугармаа	Б.Билэвчигэл
4	2023.02.20		2.5м 2.1м								Б.Билэвчигэл	Б.Билэвчигэл
5	2023.3.17		4м 1м								Г.Эрэн	Б.Билэвчигэл
6	2023.4.13		8м 5м								Г.Эрэн	Ч.Ариунзори
7	2023.05.10		5 4.5м								С.Орво	Б.Билэвчигэл
8	2023.05.22		15м 1м								Б.Билэвчигэл	Б.Билэвчигэл
9	2023.06.14		6.9м 1.4м								Г.Билэвчигэл	Б.Билэвчигэл
10	2023.06.26		15м 1.2м								Б.Билэвчигэл	Б.Билэвчигэл
11	2023.07.10		5.1м 1.7м								Б.Билэвчигэл	Б.Билэвчигэл
12	2023.07.24		5.2м 1.2м								Б.Билэвчигэл	Б.Билэвчигэл
13	2023.08.07		4.0 3.5								Б.Билэвчигэл	Б.Билэвчигэл
14	2023.08.18		7.0 2.0								Б.Билэвчигэл	Б.Билэвчигэл
15	2023.08.29		3.5 1.2								М.Уугармаа	Б.Билэвчигэл
16	2023.09.11		2.4 1.5								М.Уугармаа	Б.Билэвчигэл
17	2023.09.21		3.5 1.2								Б.Билэвчигэл	Б.Билэвчигэл
18	2023.09.27		1.2 1.2								Б.Билэвчигэл	Б.Билэвчигэл
19	2023.10.11		1.1м 1.2м								М.Уугармаа	Б.Билэвчигэл
20	2023.10.23		5.5м 2.0м								Б.Билэвчигэл	Б.Билэвчигэл
21												
22												
23												
24												
25												
26												
27												
28												
29												
30												
31												

Зураг 60. Эмнэлэгийн хог хаягдлын бүртгэлийн маягт

8.3.2 Засварын газраас гарсан ашигласан тос масолыг хуримтлуулж хадгалах.

Уурхайд ашиглаж буй техник хэрэгслүүдийн засвар үйлчилгээ, засварын газраас гарч буй ашигласан тос масолыг 20 тоннийн багтаамжтай 2 ёмкост хадгалж хяналт тавин ажиллаж байна. Цаашид засвар үйлчилгээнээс гарсан аюултай хог хаягдал болох ашигласан аккумулятор, тос маслоны шүүр, агаар шүүгч, батарей, ашигласан тос масло гэх мэт аюултай хог хаягдлыг тусгай зөвшөөрөлтэй “Түмэн эгшигт ХХК”-д нийлүүлэхээр хамтран ажиллах гэрээ байгуулах хүсэлт хүргүүлэн ажилласан.





Зураг 62. Аюултай хог хаягдлын хадгалат ба цуглуулах талбай

8.3.3 Аюултай хог хаягдлыг ангилан ялгах сургалт сурталчилгааг ажилчдад өгөх.

2023 оны 04 сарын 10-аас 05 сарын 10-нийг хүртэлх 1 сарын хугацаанд экспортын нүүрс тээврийн 26 компанийн 816 жолоочид тээврийн зам дагуух хог хаягдлын ангилан ялгалтын талаарх сургалт орж мэдээлэл өгсөн. Мөн засварын газрын ажилчид, болон катеринг компанийн үйлчилгээний ажилтнуудад оффис, амрах байрнуудаас гарч байгаа ахуйн хэрэглээний хог хаягдлыг ангилан ялгах тухай сургалтыг зохион байгуулж ажилласан.



Зураг 61. Хог хаягдлын ангилан ялгалтын сургалтыг үйлчилгээний ажилтнууд болон оффисын ажилтнуудад орж байгаа нь



Зураг 62. Хог хаягдлын ангилан ялгалтын сургалтыг тээврийн жолооч нарт орж байгаа нь.

ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Нийт зардал мян.төг	Биелэлтийн шалгуур	Баримтлах стандарт, арга, аргачлал
Гадаргын ба газар доорхи усны хяналт шинжилгээ						
1	Хөшөөтийн уурхай орчмын уст цэгүүдийн усыг химийн ерөнхий шинжилгээнд улиралд нэг удаа мэргэжлийн лабораториор шинжлүүлэх	Хөшөөтийн уурхай орчмын уст цэгүүд	Улирал 64 удаа	2,748,100	2023 оны 3, 5, 10 дугаар саруудад Хөшөөтийн уурхай, Үенч Гаалийн хяналтын талбайн уст цэгүүдээс 26 дээж авч, МХЕГ-н Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори, Усны хяналтын төв лабораторид хүргүүлж усны ерөнхий химийн шинжилгээнд хамруулсан. <ul style="list-style-type: none"> ✓ Түвшин буйрийн рашаан ✓ Тахилтын булаг ✓ Хөшөөтийн гол ✓ Уурхайн худаг ✓ Үенч ГХТ ашиглалтын худаг ✓ Үенч голын ус 	MNS0900:2010 MNS4586:1998
2	Үенч ГХТ-н ашиглалтын худаг, Үенч голын усыг химийн ерөнхий шинжилгээнд улиралд нэг удаа мэргэжлийн лабораториор шинжлүүлэх	Үенч ГХТ орчмын уст цэгүүд	Улирал 24 удаа			Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүд нь “Үндны усны стандарт MNS0900:2018”-ын шаардлага хангаж байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 9.1.1 дүгээр бүлгээс харна уу
3	Үенч сум Хөх үзүүр баг сумын төвийн худгийн усыг химийн ерөнхий шинжилгээнд мэргэжлийн лабораториор шинжлүүлэх	Үенч сум Хөх үзүүр баг	Улирал 4 удаа		2023.05.29-нд Үенч сумын төвийн худаг, Булган голын уснаас дээж авч “Монгол ус” ТӨҮГ-т Ерөнхий химийн шинжилгээнд хамруулсан. Шинжилсэн дээжний химийн үндсэн үзүүлэлтүүд нь “Үндны усны стандарт MNS0900:2018”-ын шаардлага хангаж байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 9.1.2 дугаар бүлгээс харна уу	MNS0900:2010 MNS4586:1998
4	Булган голын усыг химийн ерөнхий шинжилгээнд мэргэжлийн лабораториор шинжлүүлэх	Булган сум Булган гол	Улирал 4 удаа			
5	Уурхай орчмын уст цэгүүдийн усыг хүнд металлын шинжилгээнд мэргэжлийн лабораториор шинжлүүлэх	Хөшөөтийн уурхай орчмын уст 5 цэг	Улирал 20 удаа		2023 оны 3, 5, 8 дугаар саруудад Хөшөөтийн уурхай орчмын уст цэгүүд болон Үенчийн гаалийн хяналтын бүс орчмын уст цэгүүдээс дээж авч “Усны хяналтын төв лаборатори, МХЕГ-н Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторит хүргүүлэн хүнд металлын шинжилгээнд хамруулсан. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 9.1.3 дугаар бүлгээс харна уу	MNS0900:2018
6	Үенч ГХТ орчмын уст цэгүүдийн усыг хүнд металлын шинжилгээнд мэргэжлийн лабораториор шинжлүүлэх	Үенч ГХТ орчмын уст 2 цэг	Улирал 8 удаа			

7	Бохир усны химийн шинжилгээ	Хөшөөтийн уурхайн цэвэрлэх байгууламж	2 удаа		2023.10.07 нд уурхайн цэвэрлэх байгууламжаас бохир усны дээж авч MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага стандартын үзүүлэлтүүдээр шинжилгээ хийлгэхээр илгээсэн. Шинжилгээний хариу ирээгүй байна.	MNS ISO 6222:1998
8	Гадаргын болон газар доорхи усны мониторингийн хэмжилт	Хөшөөтийн уурхайн 6 цэг	Хоног 14	Үйл ажиллагааны зардлаас	<p>Уурхай орчмын уст цэгүүдийн байршлыг тэмдэгжүүлж мониторинг хэмжилтийг Газар доорхи усны хяналтын 2 цэгт, Гадаргын усны хяналтын 3 цэгт 3 хоногт нэг удаагийн давтамжтай хийж мэдээг бүртгэж байна. Үүнд</p> <p>Газар доорхи усны мониторинг хэмжилт (Газар доорхи усны түвшин / метр)</p> <ul style="list-style-type: none"> ✓ Хяналтын цооног Well-1 ✓ Хяналтын цооног ВН-D-3 <p>Гадаргын усны мониторинг хэмжилт (Урсац м3/с, Хурд м/с, Түвшин / м, Өргөн / м)</p> <ul style="list-style-type: none"> ✓ Далангийн системийн доор ✓ Мөрөнгийн ам ✓ Мөрөнгийн бригадыг урд ✓ Тахилтын булаг Дэлгэрэнгүйг тус тайлангийн 9.1.4 дүгээр бүлгээс харна уу 	
9	Гадаргын усны мониторингийн хэмжилт	Булган голын эхэнд	1 удаа	854,727.27	Ховд аймгийн Дарви сумын нутагт байрлах МоEnCo ХХК-ны 2023 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан /гадаргын усны мониторингийн хэмжилт/ Ховд аймаг Булган сумын “ Булган голын эх” газруудад Үенч Бодонч Булган голын сав газрын захиргааны мэргэжилтэнгүүдтэй хамтран хийж гүйцэтгэсэн. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 9.1.5 дугаар бүлгээс харна уу	
10	Урд онуудад хамгаалсан уст цэгийн мониторинг судалгаа хийх	Дарви, Үенч сум	1 удаа	Үйл ажллагааны зардлаас	2021 онд хашиж хамгаалсан Дарви сумын Мөрөн багийн Цагаан давааны булгийн эхийн тор эвдэрсэн байсан тул 2023 онд торыг сольж шинээр хүрээтэй тороор торлож гагнуулсан.	
	Нийт			3,602,827.27		

Агаарын чанарын хяналт шинжилгээ						
11	Агаарын төлөв байдал чанарын болон тоосны судалгаа шинжилгээ хийх	Хөшөөт төсөл	Жил	27,272,727.27	Уурхайн орчмын агаарын чанарын судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэж дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна. Нэгдсэн байдлаар тайлан ирээгүй байна. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 9.2 дугаар бүлгээс харна уу	MNS4585:2007 Агаарын чанар, техникийн ерөний шаардлага
12	Уурхай орчмын гадаад орчны агаарын чанарын /PM10, PM2.5 тоос/ хэмжилт хийх	Хөшөөт төсөл 10 цэгт	хоног	Үйл ажиллагааны зардлаас	Уурхай орчмын агаарын чанарын хяналтын 10 цэгт таних тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан. Хөшөөтийн уурхай орчмын агаарын бохирдол тоосны хэмжилтийг уурхай орчмын хяналтын 10 цэгт /pm2.5, pm10/ АНУ-д үйлдвэрлэгдсэн “DustTrak II Aerosol Monitor” багажаар 14 хоногт 1 удаагийн давтамжтай хийж мэдээллийн сан үүсгэн тухайн жилийн байгаль орчны менежмент төлөвлөгөөний биелэлтийн тайланд тусган ажиллаж байна. “DustTrak II Aerosol Monitor” багаж нь АНУ-д үйлдвэрлэсэн багаж юм ажиллагаа нь бодит хугацаан дахь аэрозолын масс концентрацийг лазер сарнилын фотометрийн аргаар 10 микроноос бага хэмжээтэй PM2.5, PM10 тоосонцруудыг нэгэн зэрэг шууд хэмждэг автомат багаж юм. “DustTrak II Aerosol Monitor” багажны үйлдвэрийн тохиргоог АНУ-ын TSI-н үйлдвэрт хийлгэдэг ба 2021.07.19, 2023.06.28нд хийлгэсэн. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 9.2.1 дүгээр бүлгээс харна уу	MNS4585:2007 Агаарын чанар, техникийн ерөний шаардлага
Нийт				27,272,727.27		
Хөрсний судалгаа шинжилгээ						
13	Уурхай орчмын хөрсний мониторингийн цэгээс дээж авч шинжилгээнд хамруулах	Уурхай орчмын мониторингийн цэгүүдээс	Улирал 84 удаа	19,993,300	Уурхай орчмын хяналтын 16 цэг, Үенч гаалийн хяналтын талбайн 6 цэгээс дээж авч улиралд 1 удаа Хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид” 2, 3 дугаар улирлын харсний дээжийг “Дээж хөрс судал, усны итгэмжлэгдсэн лабораторид Химийн үндсэн шинж, механик бүрэлдэхүүн, хүнд металлын агууламжыг тодорхойлуулж байна. Нэг, хоёр, гуравдугаар улирлын дээжийг 2023.03, 05, 07 дугаар сард авч шинжилгээнд хамруулсан. Дээжний үндсэн үзүүлэлтүүд бохирдолгүй хэвийн хэмжээнд байна. Мөн БОАЖЯ-ны Дэлгэрэнгүйг тус тайлангийн 9.3 дугаар бүлгээс харна уу	БОНБҮТ хууль

14	Мониторингийн цэгээс дээж авч цацрагийн шинжилгээ хийлгэх	Хөшөөтийн уурхай, Үенч ГХТ	Улирал 16 удаа		2023 оны 7 дугаар сард уурхайн шимт хөрсний талбайгаас дээж авч цацрагийн шинжилгээнд хамруулсан. ✓ Цацрагийн шинжилгээ - 1 дээж МХЕГ-ын ХАБҮЛ лаборатори Дэлгэрэнгүйг тус тайлангийн 9.3 дугаар бүлгээс харна уу	Аудитын үл нийцэл
Нийт				19,993,300		
Ургамал, Амьтны аймгийн судалгаа						
15	Уурхайн орчимд хийгдсэн амьтан ургамлын судалгааг үргэлжлүүлэн үе шаттайгаар зохион байгуулж судлан, шаардлагатай арга хэмжээг төлөвлөх	Уурхай орчим	1 удаа	17,235,297	МУИС-ын Ховд аймаг дахь салбар сургуулийн Биологийн тэнхимийн багш судлаач нартай хамтран Хөшөөт уурхайн орчимд ургамал, амьтаны аймгийн судалгаа хийж ажиллаа. Дэлгэрэнгүйг тус тайлангийн 9.4 дүгээр бүлгээс харна уу	БОНБҮТ ХУУЛЬ
Нийт				17,235,297		
ОХШХ-н нийт зардал, мян.төг				67,249,424.27		

9.1 Гадаргын ба газар доорхи усны хяналт шинжилгээ

9.1.1 Хөшөөтийн уурхай орчмын уст цэгүүдийн усыг химийн ерөнхий шинжилгээнд мэргэжлийн лабораториор шинжлүүлэх

Хөшөөтийн уурхай орчмын гадаргын болон газар доорхи ус, карьер дахь шүүрлийн ус, Үенч гол, Булган гол, Үенч сумын төвийн худаг зэрэг цэгүүдээс дээж авч улиралд 1 удаа Улаанбаатар хот руу усны хяналтын лабораториуд болох “ХАБҮЛ лаборатори”, “Монгол-Ус” ТӨҮГ-руу” явуулж усны ерөнхий хими, хүнд металлын шинжилгээнд хамруулж байна.

2023.03.27-нд Нэгдүгээр улирлын усны дээжийг уурхай орчмын 6 цэгээс ерөнхий хими -6, хүнд металл-2 нийт 8 дээж авч “Монгол-Ус” ТӨҮГ”-ын лабораторлуу явуулж шинжилгээнд хамруулсан /дээжний үндсэн үзүүлэлтүүд “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, “Усан орчны чанарын үзүүлэлтийн шаардлагыг хангаж байна. /хавсралт I/

Уурхай орчмын уст цэг:

- Уурхайн худаг /ерөнхий хими/
- Түвшин буйрын рашаан /ерөнхий хими/
- Тахилтын булаг /ерөнхий хими/
- Хөшөөт гол /ерөнхий хими/
- Шүүрлийн ус (WDH-02) цооног /ерөнхий хими, хүнд металл/
- Шүрлийн ус (WDH-03) цооног /ерөнхий хими, хүнд металл/

2023.05.24-нд Хоёрдугаар улирлын усны дээжийг уурхай орчмын 7, Үенч сумын төвийн худаг-1, Булган гол-1, Үенч гол-1 нийт 10 цэгээс ерөнхий хими -10, хүнд металл-10 нийт 24 дээж авч “ХАБҮЛ” лабораторлуу шинжилгээнд явуулсан.

Усны дээж авсан цэг:

- Уурхайн худаг /ерөнхий хими, хүнд металл/
- Хөшөөт гол /ерөнхий хими, хүнд металл /
- Түвшин буйрын рашаан /ерөнхий хими, хүнд металл /
- Тахилтын булаг /ерөнхий хими, хүнд металл /
- Шүүрлийн ус /ерөнхий хими, хүнд металл /
- Шүүрлийн ус (WDH-02) цооног /ерөнхий хими, хүнд металл/
- Шүрлийн ус (WDH-03) цооног /ерөнхий хими, хүнд металл/
- Булган гол /ерөнхий хими, хүнд металл/
- Үенч гол /ерөнхий хими, хүнд металл/
- Үенч сумын төвийн худаг /ерөнхий хими, хүнд металл/

2023.10.07-нд Хөшөөтийн уурхай МоЭнКо ХХК-ийн ажилчдын амрах байр, оффисийн цэвэрлэх байгууламжуудаас бохир усны 3 дээж авч Улаанбаатар хот “ХАБҮЛ” лаборатори /MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин, Усны чанар, Хаягдал ус, Ерөнхий шаардлага/- стандартын дагуу шинжилгээнд явуулсан. Мөн уурхай орчмын уст цэгүүд болон Үенчийн гаалийн хяналтын бүсийн уст цэгүүдээс нийт 9 дээж авч хүнд металлын агууламж болон ерөнхий химийн шинжилгээ хийлгэхээр явуулсан. Дээжийн хариу одоогоор ирээгүй байна.

Усны дээж авсан цэг:

- Оффис цэвэрлэх байгууламж-1
- Ажилчдын кемпийн цэвэрлэх байгууламж-2
- Уурхайн худаг /ерөнхий хими, хүнд металл/
- Хөшөөт гол /ерөнхий хими, хүнд металл /
- Түвшин буйрын рашаан /ерөнхий хими, хүнд металл /
- Тахилтын булаг /ерөнхий хими, хүнд металл /
- Шүүрлийн ус /ерөнхий хими, хүнд металл /
- Шүүрлийн ус (WDH-02) цооног /ерөнхий хими, хүнд металл/
- Шүрлийн ус (WDH-03) цооног /ерөнхий хими, хүнд металл/
- Булган гол /ерөнхий хими, хүнд металл/
- Үенч гол /ерөнхий хими, хүнд металл/

- Үенч сумын төвийн худаг /ерөнхий хими, хүнд металл. Шинжилгээний хариуг хавсралтаас харна уу.



Зураг 63. Хөшөөтийн гол болон рашаан /усны дээж/



Зураг 64. Үенч сумын төвийн худаг болон Булган, Үенч гол/усны дээж/

9.1.2 Үенч сум Хөх үзүүр баг сумын төвийн худаг, Булган голын усыг химийн ерөнхий шинжилгээнд мэргэжлийн лабораториор шинжлүүлэх

Үенч сумын төвийн худаг, Булган голоос дээж авч “Монгол ус” ТӨҮГ-т Ерөнхий химийн шинжилгээнд хамруулсан. Шинжилсэн дээжийн химийн үндсэн үзүүлэлтүүд нь “Ундны усны стандарт MNS0900:2018”-ын шаардлага хангаж байна. *Шинжилгээний хариуг хавсралтаас харна уу.*



Зураг 65. Булган гол /Ерөнхий химийн шинжилгээ

9.1.3 Хөшөөтийн уурхай, Үенч Гаалийн хяналтын талбайн уст цэгүүдийн усыг хүнд металлын шинжилгээнд мэргэжлийн лабораториор шинжлүүлэх

Хөшөөтийн уурхай орчмын уст цэгүүдээс дээж авч “Монгол ус” ТӨҮГ-т хүргүүлэн хүнд металлын шинжилгээнд хамруулсан. *Шинжилгээний хариуг хавсралтаас харна уу.*

- Түвшин буйрийн рашаан
- Тахилтын булаг
- Хөшөөтийн гол
- Уурхайн худаг
- Well 1 цооног
- Үенч гол
- Ашиглалтын худаг



Зураг 66. Уст цэгүүдийн хүнд металлын шинжилгээ

9.1.4 Гадаргын болон газар доорхи усны мониторингийн хэмжилт

Уурхай орчмын уст цэгүүдийн байршлыг тэмдэгжүүлж мониторинг хэмжилтийг Газар доорхи усны хяналтын 2 цэгт, Гадаргын усны хяналтын 3 цэгт 7 хоногт нэг удаагийн давтамжтай хийж мэдээг бүртгэж байна.


Газар доорхи усны мониторинг хэмжилт (Газар доорхи усны түвшин / метр)

- Хяналтын цооног Well-1
- Хяналтын цооног ВН-D-3

Гадаргын усны мониторинг хэмжилт (Урсац м3/с, Хурд м/с, Түвшин / м, Өргөн / м)

- Далангийн системийн доор
- Мөрөнгийн ам
- Мөрөнгийн бригадын урд
- Тахилтын булаг







Зураг 67. Гадаргын болон газар доорхи усны мониторинг хэмжилт



Зураг 68. Гадаргын болон газар доорх усны хэмжилтийн багаж



Зураг 69. Усны дээж авах хяналтын цэгийн байршил



Зураг 70. Хөшөөтийн уурхайн усны мониторинг хэмжилтийн цэгийн байршил

9.1.5 Гадаргын усны мониторингийн хэмжилт /Булган Үенч голын эхэнд/

Ховд аймгийн Дарви сумын нутагт байрлах МоЭнКо ХХК-ийн 2023 оны хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан Гадаргын усны мониторингийн хэмжилт болон усны тоо бүртгэлийн 1 удаагийн ажлыг зохион байгуулж хийлээ.

Үүнд: Үенч, Бодонч, Булган голын сав газрын захиргааны Ахлах мэргэжилтэн Б.Мөнхбат, мэргэжилтэн Б. Мэргэн, мэргэжилтэн Н.Нандинцэцэг, Жолооч Ц.Даваажав МоЭнКо ХХК-ийн ахлах гидрогеологич Б.Басбаатар, Л.Бямба-Очир, З.Билгүүн нарын бүрэлдэхүүнтэй 2023 оны 9 сарын 25-өөс 9 сарын 28-ны хооронд Булган сумын нутаг Дээд нарийн, Доод нарийн, Сөнхөл,Таван хумст, Шүвтэр, Ендэртийн ам, Бумбат гэсэн маршрутаар явж гадаргын усны мониторингийн хэмжилтийг Үенч гол, Булган голын цутгал том жижиг нийт 7 гол, 13 булаг 2 нууранд мониторингийн судалгаа хийсэн.



Зураг 71. Булган гол усны хэмжилт, дээж авалт

9.2 Агаарын чанарын хяналт шинжилгээ

1. Мэргэжлийн байгууллагын судалгаа.

Хөшөөтийн чулуун нүүрсний уурхай орчмын агаарын чанар хяналт шинжилгээг жил бүр мэргэжлийн байгууллагаар хийлгэж дүгнэлт, зөвлөмж гаргуулж ажилладаг. 2018, 2019, 2020, 2022 оны агаарын чанарын судалгааг тухайн орчин бүс нутгийг төлөөлж чадахуйц 5 цэг тогтоож цэг тус бүрээс хүхэрлэг хий SO_2 , азотын давхар исэл NO_2 -ийн сорьц авч, $PM_{2.5}$, PM_{10} тоосонцрын хэмжилтийг хийлгэсэн.

Агаарын чанарын хяналт шинжилгээг үндэсний (MNS) стандарт арга, аргачлалын дагуу тоосонцрын хэмжээг тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга, агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, агаар дахь хүхрийн хийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга болон автомат багаж төхөөрөмж ашиглан шууд хэмжлийн аргаар тодорхойлсон. Өмнөх онуудын хяналт шинжилгээгээр агаар бохирдуулагч бодисуудын агууламж нь стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс хэтрээгүй гэж дүгнэсэн.

2023 оны агаарын чанарын хяналт шинжилгээг мэргэжлийн байгууллага болох “Green Asia consulting” ХХК-иар 2023 оны 11 сарын 25-28 ны хооронд Хөшөөтийн уурхайд ирж дээж авах судалгааны ажил хийж тайлан мэдээ нэгтгэн боловсруулах, дүгнэлт гаргуулан ажилласан.




Зураг 72. Мэргэжлийн байгууллага агаарын чанарын судалгааны хэмжилт хийж байгаа нь

Дуу шуугианы түвшин уурхай орчмын 10 цэгт Digital Environment Multimeter EM5 багажаар 14 хоногт 1 удаагийн давтамжтай хийж мэдээг бүртгэж байна.

Монгол Улсын дуу чимээний стандарт (MNS 4585: 2017) болон ДЭМБ-ын заавар дахь хүлцэх хэм хэмжээнээс даваагүй хэвийн байна.

Хэмжүүр	MNS Стандарт Дб(А)		ДЭМБ-ын заавар Дб (А)	
	Өдрийн цаг	Шөнийн цаг	Өдрийн цаг	Шөнийн цаг
	07:00 – 23:00	23:00 – 07:00	07:00 – 22:00	22:00 – 07:00
Олон нийтэд орчны дуу чимээний үзүүлэх хамгийн дээд хэмжээ	60	45	ДЭМБ ангилал I - Сууршлын, институтын, боловсролын: 55	ДЭМБ ангилал I - Сууршлын, институтын, боловсролын: 45
			ДЭМБ ангилал II - Аж үйлдвэрийн, худалдаа үйлчилгээний: 70	ДЭМБ ангилал II - Аж үйлдвэрийн, худалдаа үйлчилгээний: 70

Эх сурвалж: MNS 4585: 2007 болон ДЭМБ Дуу чимээний чанарын удирдамж (1999) ОУСК-ын байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдамж (2007)



Зураг 73. Төслийн талбайн дуу шуугианы хэмжилт

9.2.1 Агаарын чанар дотоод хяналт мониторинг


Уурхай орчмын агаарын чанарын хяналтын 10 цэгт таних тэмдэг тэмдэглэгээ байрлуулсан.

Хөшөөтийн уурхай орчмын агаарын бохирдол тоосны хэмжилтийг уурхай орчмын хяналтын 10 цэгт / $pm_{2.5}$, pm_{10} / АНУ-д үйлдвэрлэгдсэн “DustTrak II Aerosol Monitor” багажаар 14 хоногт 1 удаагийн давтамжтай хийж мэдээллийн сан үүсгэн тухайн жилийн байгаль орчны менежмент төлөвлөгөөний биелэлтийн тайланд тусган ажиллаж байна.


Тоосны хэмжилтийн багаж “DustTrak II Aerosol Monitor”

“DustTrak II Aerosol Monitor” багаж нь АНУ-д үйлдвэрлэсэн багаж юм ажиллагаа нь бодит хугацаан дахь аэрозолын масс концентрацийг лазер сарнилын фотометрийн аргаар 10 микроноос бага хэмжээтэй $PM_{2.5}$, PM_{10} тоосонцруудыг нэгэн зэрэг шууд хэмждэг автомат багаж юм.

“DustTrak II Aerosol Monitor” багажны үйлдвэрийн тохиргоог АНУ-ын TSI-н үйлдвэрт 2023 оны 5 сарын 1 хийлгэсэн.



Зураг 74. Тоосонцор хэмжилтийн DustTrak багаж




CERTIFICATE OF CALIBRATION AND TESTING

TSI Incorporated, 500 Cardigan Road, Shoreview, MN 55126 USA
 Tel: 1-800-874-2811 1-651-490-2811 Fax: 1-651-490-3824 http://www.tsi.com


Environment Conditions				Model	8530
Temperature	73.2 (22.9)	°F (°C)		Serial Number	8530175122
Relative Humidity	27	%RH			
Barometric Pressure	28.77 (974.3)	inHg (hPa)			

As Left
 As Found

In Tolerance
 Out of Tolerance



Concentration Linearity Plot




System ID: DT1101-02

FLOW AND PRESSURE VERIFICATION				SYSTEM DT1101-02			
Parameter	Standard	Measured	Allowable Range	Parameter	Standard	Measured	Allowable Range
Flow lpm	3.00	3.04	2.85 - 3.15	Pressure kPa	97.5	97.1	92.59 - 102.34
Full Flow lpm	N/A	4.20	>3.80				

Pump run time: 130 Hours, Pump voltage: 201 Bits
